



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



**БИЧИЛ УУРХАЙГААС ОЛБОРЛОСОН АЛТ
БОЛОН ДАГАЛДАХ ҮНЭТ МЕТАЛЛЫН
ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН СТАНДАРТЫН
ХУРААНГУЙ**



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ УУРХАЙГААС ОЛБОРЛОСОН АЛТ БОЛОН ДАГАЛДАХ ҮНЭТ МЕТАЛЛЫН ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН СТАНДАРТЫН ХУРААНГУЙ

Улаанбаатар хот
2017 он

ДАА-551
НАА-26.3
Б-505

БИЧИЛ УУРХАЙГААС ОЛБОРЛОСОН АЛТ БОЛОН ДАГАЛДАХ ҮНЭТ МЕТАЛЛЫН ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН СТАНДАРТЫН ХУРААНГУЙ

©Бүх эрхийг Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл эзэмшинэ.

ISBN 978-99978-851-1-1

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
1. СТАНДАРТЫН ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
1.1 ХАРИУЦЛАГАТАЙ БИЧИЛ УУРХАЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗАРЧМУУД	7
1.2 ХАМРАХ ХҮРЭЭ	9
1.3 БУБ-ЫН ОЛБОРЛОЛТЫН ТАЛБАЙ БА ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СИСТЕМ	14
1.3.1 Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд оруулах ажиллагаа	14
1.3.2 Шудрага олборлолтын ердийн ба экологийн алт үйлдвэрлэлийн зэрэгцээ систем	16
1.3.3 БУБ-ын бичил уурхайчид, орон нутгийн байгаль орчны талаар хүлээх зайлшгүй үүрэг хариуцлага	16
1.4 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЦАР ХҮРЭЭ	17
1.4.1 Дайвар бүтээгдэхүүн	18
1.4.2 Шударга олборлолтын алтны тусгай бүтээгдэхүүний тодорхойлолт	18
1.4.3 Шударга олборлолтын мөнгө, цагаан алтны тусгай бүтээгдэхүүний тодорхойлолт	19
1.5 ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ БА ҮЛ ХАМРАГДАХ ГАЗРУУД	19
1.6 БҮТЭЦ	21
1.7 ЛАВЛАХ МАТЕРИАЛУУД	21
1.8 НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН ХЯНАЛТ	23
2. СТАНДАРТЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	24
2.1 ЗОРИЛГО	24
2.2 ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭНД ХАМРАГДАХ	24
2.3 ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	25
2.4 БУБ-ЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	27
2.5 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛТ	31
2.5.1 Хорт бодисын менежмент	31
2.5.2 Экосистемийн хамгаалалт	34
2.5.3 Экологийн алт, мөнгө, цагаан алт	36

2.6	ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ	37
2.6.1	Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал	38
2.6.2	Нийгмийн хамгаалал	40
2.6.3	Ажил эрхлэлтийн нөхцөл	41
2.6.4	Хөдөлмөрлөх эрх чөлөө	43
2.6.5	Хүүхэд хамгаалал ба хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсоох үүрэг	44
2.6.6	Үл ялгаварлан гадуурхагдах эрх чөлөө	46
2.6.7	Эвлэлдэн нэгдэх, хамтран тохиролцох эрх чөлөө	47
2.7	ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН ШАГНАЛЫН УДИРДЛАГА БА ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	49
2.8	ХУДАЛДААНЫ ХАРИЛЦАА	52
2.8.1	Шударга олборлолтын биет нийлүүлэлтийн загварын хүрээнд дагах Стандартын үзүүлэлтүүд	53
2.8.2	Шударга олборлолтын гэрчилгээний загварт хэрэглэгдэх стандартын үзүүлэлт	61
3.	ХАВСРАЛТУУД	64
3.1	ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН СТАНДАРТЫН ЗАХ ЗЭЭЛ	64
3.2	НЭР ТОМЪЁОНЫ ХАВСРАЛТ	71

ӨМНӨХ ҮГ

Шударга олборлолтын (ШО) стандарт нь хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд чиглэдэг бөгөөд сайн засаглал, хууль эрхзүй, оролцоо, олон талт байдлыг дээдлэх хүрээнээс үүсч хөгжин, улмаар тогтвортой эрдэс баялаг, ёс зүйтэй үнэт эдлэл, хариуцлагатай гарал үүсэл бүхий алтан эдлэл хэрэглэх гэсэн хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэн аливаа улсад ажлын байр бий болгох, орон нутгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, баялаг бүтээх, нийгмийн дэг журмыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг.

Энэхүү стандартыг Колумб Улсад төвтэй Хариуцлагатай уул уурхайн холбоо (ХУУХ) олон улсын байгууллагаас гарган хэрэгжүүлдэг. Тус стандартыг нэвтрүүлснээр бичил уурхайчид олон улсын түвшинд үйл ажиллагаа нь хүлээн зөвшөөрөгдөж, олборлосон эрдэс баялгаа олон улсын зах зээл дээр дэлхийн зах зээлийн ханшаар борлуулан, улмаар тодорхой хэмжээний урамшуулал хүртэж бичил уурхайн үйл ажиллагаагаа дэмжих нөхцөл бүрдэнэ. Урамшуулал нь хууль журмын дагуу, ШО-ын стандартын хүрээнд ёс зүйтэй үйл ажиллагаа явуулан, тогтвортой сайн ажлын байр бий болгож, ядуурлыг бууруулахад болон нийгмийн дэг журмыг бий болгоход хувь нэмрээ оруулж буй байдлыг үнэлж олгож байгаа шагнал юм. Тус шагнал нь бичил уурхайчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллөө нэмэгдүүлэхэд зарцуулагдах юм.

Монголын бичил уурхайчдын хувьд тус стандартыг нэвтрүүлж ажилласнаар хуулийн хүрээнд зохион байгуулалтад орж, хариуцлагатай бичил уурхайг эрхлэх, нийгэмд бичил уурхайчдыг эерэгээр таниулах, өөрсдийн хөгжлийг дэмжих боломжийг бүрдүүлэх, ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой юм. Мөн тус стандарт нь олон улсын хэмжээний хүний эрхэд суурилсан бичил уурхайн хөгжлийг дэмжих хандлагыг Монгол Улсын хэмжээнд нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Монгол Улс “Алт-2” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлан

хэрэгжүүлэхээр болсон. Үүнтэй уялдуулан төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх замаар улс эх орны эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийг хангах зорилтууд тусгагдсан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болсон байна.

Монголбанкны мэдээгээр дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувь, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн 9.6 хувь, экспортын орлогын 9.1 хувийг алтны үйлдвэрлэл эзэлж байгаа нь алт Монгол Улсын эдийн засагт ихээхэн нөлөөтэй болохыг харуулж байна. Түүнчлэн 2016 онд Монголбанканд тушаасан 18.6 тонн алтны-ийг иргэдээс тушаасан байна.

Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлэх, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхыг өсгөхөд алтны шударга олборлолт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Иймээс бичил уурхайчид та бүхэндээ Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслөөс Шударга олборлолтын стандартын гарын авлагыг өргөн барьж байна.

Б.АЛТАНБАГАНА

Тогтвортой бичил уурхай төслийн Үндэсний зохицуулагч

**1.1 Хариуцлагатай бичил уурхайн алсын хараа,
зорилго, зарчмууд**

СТАНДАРТ нь бичил уурхай эрхлэгчид (уурхайн ажлыг газар тариалан, мал аж ахуй, болон хөдөө аж ахуйн бусад үйл ажиллагааг хослуулан эрхэлдэг бичил уурхайчид), тэдгээрийн бүлгүүдэд таатай боломжийг бий болгож өгөх зорилготой бөгөөд Бичил уурхайн байгууллага болон Хариуцлагатай Уул Уурхайн Холбоо (ХУУХ) байгууллагын Хариуцлагатай бичил уурхайн алсын харааг мөрдлөг болгоно.

Хариуцлагатай бичил уурхай алсын хараа нь “Бичил уурхай бол үр ашигтай технологи ашигладаг албан ёсны, зохион байгуулалттай, ашигтай үйл ажиллагаа бөгөөд нийгмийн болон байгаль орчны хувьд хариуцлагатай байна”.

СТАНДАРТ-ын ерөнхий зорилго нь бичил уурхайн салбар аажмаар зохион байгуулалтад орж, албан ёсны болохыг хөхиүлэн дэмжих, уурхайчдын хөдөлмөр эрхлэх, аюулгүй нөхцөлд ажиллах эрхийг сайжруулах, уурхайчдын байгууллагуудыг бэхжүүлж өөрсдийн эрхийг хамгаалах, хариуцлагатай бичил уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хууль тогтоомж, төрийн бодлогод нөлөөлөх чадавхтай болгоход оршино.

Алсын хараа, зорилго нь сайн засаглал, хууль ёст байдал, оролцоо, олон талт байдлыг дээдлэх хүрээнээс аажмаар үүсч хөгжин, улмаар тогтвортой эрдэс баялаг, ёс зүйтэй үнэт эдлэл, хариуцлагатай эх сурвалж бүхий алтан эдлэл хэрэглэх гэсэн хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, нийгмийн хөрөнгө оруулалтын адил тэгш боломж олгох замаар эрдэс баялаг ихтэй экосистем бүхий нутагт амьдарч буй нутгийн иргэдэд үр өгөөжөө өгч, аливаа улсад ажлын сайн байр бий болгох, орон

нутгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, баялаг бүтээх, нийгмийн дэг журмыг бий болгоход хувь нэмрээ оруулахаас гадна байгаль орчны менежментийг сайжруулах, ялангуяа мөнгөн ус болон химийн бусад хорт бодис ашиглахыг явдлыг багасгах, экологийн нөхөн сэргээлтийг нэмэгдүүлэх, усны нөөцийн хариуцлагатай менежментийг сайжруулахад хүргэхээс гадна уурхайчдын гэр бүл, үр хүүхдүүдийн сайн сайхан байдлыг дэмжиж, нийгмийн хамгаалал, жендэрийн тэгш байдал, хүүхэд хамгааллыг сайжруулах, итгэмжлэгдсэн байгууллагуудын хүрээнд хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсооход нөлөө үзүүлдэг. Энэ нь улмаар уул уурхайн салбарын засаглалыг сайжруулдаг.

Бичил уурхай (БУ) нь том, дунд хэмжээний уурхайтай харьцуулахад бага хэмжээний, хүний хүч хөдөлмөр их шаардсан үйл ажиллагааг хамрах бөгөөд өргөн хүрээтэй дөрвөн төрлийг тодорхойлж болно.

i. Байнгын бичил уурхай

- Бүтэн цагийн, жил тойрсон тасралтгүй үйл ажиллагаа, гол төлөв үе дамжсан эсвэл уламжлалт мөн тухайн нутагт эрхэлдэг цорын ганц эдийн засгийн үйл ажиллагаа байх эсвэл нутгийн болон хөдөөгийн иргэдийн бүлгүүд энэ ажлаасаа гадна мал аж ахуй, газар тариалан, жижиг худалдаа, эсвэл бусад олборлолтын ажил эрхлэх шинжийг агуулсан байна.

ii. Улирлын чанартай бичил уурхай

- Уул уурхай нь зарим хүмүүсийн нэмэлт орлого олох эх үүсвэр болдог учир үйл ажиллагаагаа улирлын чанартай солих буюу бичил уурхайн ажилд улирлаар шилжих мөн улирлын чанартай хотоос хөдөөд шилжин суурьших замаар үйл ажиллагаа (олборлолт) явуулах шинжтэй байна.

iii. Олноор хошуурсан бичил уурхай

- Шинээр илэрсэн орд газраас орлого олох боломж нь одоо олж байгаа бодит орлогоос нь хамаагүй илүү гэж үзсэний үндсэн дээр алт ихтэй нутаг руу олноор нүүж очих ингэснээр олноор хошууран ирж байсан газруудад суурьшин, шинэ суурин бий болж бичил уурхайн салбарт шинээр орж ирсэн ард иргэдийн

бүлэг ямагт бий болж шинчлэгдэж байдаг шинжтэй.

iv. Хямралын буюу амь аргацаасан бичил уурхай

- Бусад салбар дахь ажил эрхлэлтээ алдсан, зөрчил мөргөлдөөн, байгалийн гамшиг нүүрлэсний улмаас ядууралд орж амьжиргаагаа тэтгэхэд чиглэсэн, бичил уурхайн үйл ажиллагаанд эргэлт буцалтгүй орсон шинжтэй.

Байнгын болон улирлын чанартай бичил уурхайг гол төлөв ард иргэдийн бүлэгт тулгуурласан, удам дамжсан эсвэл уламжлалт уурхай гэж нэрлэдэг. Олноор хошуурсан ба хямралын үеийн бичил уурхай нь иргэдийн шинэ бүлэг бий болгох, иргэдийн бүлэгт тулгуурласан уул уурхай хөгжих боломж болдог. Энэ төрлийн уурхай байнгын, хууль ёсны, зохион байгуулалттай болсны дараа Шударга олборлолтын гэрчилгээ авах хүсэлт гаргаж болно.

Энэхүү СТАНДАРТ нь зөвхөн одоо оршин байгаа, зөрчилдөөнгүй, ард иргэдэд тулгуурласан, байнгын ба удлирлын чанартай бичил уурхайн үйл ажиллагааг хамрах зориулалттай юм.

СТАНДАРТ нь Бичил уурхайчдын байгууллагууд (БУБ) холбогдох улсын үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөх зарчимд тулгуурлана.

Энэхүү стандарт нь бичил уурхай эрхлэгчдэд зориулагдсан бөгөөд үйлдвэрлэлийн чанартай үйл ажиллагаа явуулдаг дунд, том уурхайн, алт олборлохоор олноор хошуурах нөхцөл байдалд болон экологийн эмзэг тогтоцтой газруудад шинээр уурхай эрхлэх ажиллагаанд зориулагдаагүй юм.

1.2 Хамрах хүрээ

“Бичил уурхайн” хамрах хүрээ нь дараах үндсэн үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно.

1. Тухайн улсын үндэсний хууль тогтоомжуудад Бичил уурхай гэсэн тогтсон тодорхойлолттой эсэх, ямар нэг тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд Өргөдлийн хорооноос гаргах шийдвэр нь дараахь зүйлсэд тулгуурласан байна:

2. Хөдөлмөрийн бүтээмжийн шалгуур.

Бүртгэлийн системд оруулах үед тухайн бүртгэлтэй уурхайчны хөдөлмөрийн бүтээмж өдөрт 4 грамм алтнаас хэтрэхгүй байгаа бол бичил уурхайд тооцно. Системд оруулснаас хойш “дотоод өсөлт, хөгжлийн” үр дүнд хөдөлмөрийн бүтээмжийн босго хэмжээг давсан БУБ-ыг тухайн бүртгэлтэй уурхайчны хөдөлмөрийн бүтээмж өдөрт 8 грамм алтнаас хэтрэх хүртэл Шударга олборлолтын гэрчилгээний системд тэнцсэн хэвээр байлгана.

Хөдөлмөрийн бүтээмж нь хүдрийн зэрэглэлээр тодорхойлогддог онцгой өндөр зэрэглэлийн гарцтай орд газруудын хувьд доорх шалгуур давамгайлж болно.

3. ЭЗХАХБ-ын тодорхойлолт.

“Гар аргаар олборлолт ба бичил уурхай нь гол төлөв хайгуул, олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн энгийн хялбар хэлбэрүүд бүхий албан ба албан бус уурхайн үйл ажиллагаанаас бүрдэнэ. (Бичил уурхай нь ихэвчлэн капитал ашиглалт багатай байж, хүний хөдөлмөр их шаардсан технологи ашигладаг бөгөөд хувиараа болон гэр бүлийн бүлэг, нөхөрлөл, хоршоо хэлбэрээр эсвэл зуун зуун, бүр мянга мянган уурхайчныг нэгтгэсэн хууль ёсны холбоод, үйлдвэрийн газар хэлбэрээр ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүс багтаж болно.)

4. Эцэст нь аливаа БУБ өөрөө Шударга олборлолтын бусад БУБ-ууд, уурхайчдын холбоод, ТББ-ууд, эсвэл бүс нутгийнхаа төрийн эрх бүхий байгууллагад хандах замаар ард иргэдийн бүлэгт тулгуурласан бичил уурхай гэсэн үнэмшилтэй нотлох баримтаар хангаж болно.

Аливаа бичил уурхайн байгууллага Шударга олборлолтын гэрчилгээжүүлэлтэд тэнцэх эсэхийг тодорхойлох нь ХУУХ-ны үүрэг бөгөөд өргөдлийн хороо нь дээрх 4 үндсэн үзүүлэлтүүдийг хослуулан ашиглана.

Байгууллагын хүрээ: СТАНДАРТ нь “Бичил уурхайн байгууллага” (БУБ)-уудад хэрэглэгдэх бөгөөд дараах үзүүлэлтүүдийг хангасан байна.

БУБ (Бичил уурхайн байгууллага)

1. БУБ бол хариуцлагатай бичил уурхай эрхлэх, удирдан зохицуулах зорилгоор байгуулагдсан албан ёсны байгууллага бөгөөд тухайн улсын хууль эрх зүй, нийгэм, соёлын нөхцөл байдал, байгууллагын бодит онцлогын дагуу байгуулагдсан байна. Аливаа БУБ нь шууд (БУБ-ын мэдлийн) эсвэл шууд бус (БУБ-ын уурхайчдын, бусад талуудтай хамтын ажиллагааны хүрээний мэдлийн) гэрээ, эрх зүйн эрхтэй, уурхай эрхлэх байгаль орчны болон холбогдох бусад зөвшөөрөлтэй байна.
2. БУБ-ын өмчлөгч нь газрын эзэд, хувь хүн, түншүүд, хувьцаа эзэмшигчид эсвэл гишүүд байж болно. БУБ нь уг байгууллагатай зорилго нэгдэн нэг дээврийн дор ажиллаж байгаа янз бүрийн бичил уурхайчдаас /хувиараа ашигт малтмал олборлогчид, гэр бүлээр олборлогчид, хувиараа олборлогчдын бүлгүүд төдийгүй ашигт малтмал сонгон олборлогчид, гэр бүлийн жижиг аж ахуй, жижиг үйлдвэрийн газар гэх мэт байгууллагууд, мөн бүх төрлийн ажилчид (түр болон нүүдлийн)/ бүрдэж болно. БУБ нь эдийн засгийн хувьд амьдрах чадвартай, соёлын хувьд зохистой гэж үзсэн тохиолдолд хамрах хүрээндээ орон нутгийн дэлгүүр, алтны мухлаг, нутгийн худалдааны төлөөлөгчдийг оруулж болно.
3. БУБ нь Шударга олборлолтын гэрчилгээ авах хүсэлт гаргагч, улмаар гэрчилгээ эзэмшигч байж болно.

БУБ-ын хамрах хүрээ: БУБ нь өөрийн хамрах хүрээнд буй уул уурхайн ажиллагаанд хяналт тавих (хуулиар эсвэл Үндсэн хуулиар) бөгөөд гэрчилгээ эзэмшигчийн хувьд энэхүү СТАНДАРТ-ын бүх шаардлагад нийцүүлэн ажиллах үүрэгтэй.

Шударга олборлолтын гэрчилгээний хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлно.

- а. Уурхай эрхлэгчдийн бүртгэл
- б. Уул уурхайн болон боловсруулалтын бүх үйл ажиллагаа, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл

БУБ Шударга олборлолтын алт болон дагалдах үнэт металлын өөрөө худалдан борлуулж болно эсвэл **Дотоод хяналтын**

систем-ээр дамжуулан Шударга олборлолтын нийлүүлэлтийн системд орж Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд нэгдсэн бүх уурхайчдынхаа худалдаанд хяналт тавьдаг байж болно. Дотоод хяналтын систем нь ийнхүү гэрчилгээ олгох урьдач нөхцөл байна. Дотоод хяналтын систем нь бие даан худалдаа эрхэлдэг олон төрлийн байгууллага нэг БУБ-д нэгдэн ажиллах ᠑боломж олгодог.

БУБ-ын үүрэг хариуцлага: Шударга олборлолтын гэрчилгээгээр баталгаажуулахыг хүссэн БУБ гурван түвшиний үүрэг хариуцлага хүлээнэ:

1. БУБ өөрийн Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системдээ энэхүү СТАНДАРТ-ын шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.
 - БУБ нь бичил уурхайчиддаа стандартын хүрээнд ажиллах зөвшөөрөл олгох хууль ёсны эрхтэй эсвэл Шударга олборлолтын гэрчилгээтэй холбоотой бүхий л асуудлаар хамтран төлөөлөхөөр уг эрхийг эзэмшигчдээс томилогдсон байх.
 - БУБ нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд оруулах уурхайчин, чиглэл, үйл ажиллагаагаа тодорхойлох ёстой.
 - БУБ нь Шударга олборлолт, үйлдвэрлэлийн системийнхээ хүрээнд хийгдсэн олборлолтоос гуравдагч этгээдэд эцэслэн борлуулах хүртэл ашигт малтмалын болон металлын урсгал ямар байгааг бүртгэж, хянах Дотоод хяналтын системтэй байна.
 - БУБ нь Шударга олборлолтын шагналыг захиран зарцуулах, түүнийг хариуцлагатай, ил тодоор удирдах үүрэгтэй. БУБ нь энэхүү шагналыг захиран зарцуулах хороо байгуулах ёстой. Хороо нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд нэгдсэн уурхайчид (шагналын орлого хүртэгчид) болон эмэгтэйчүүд, ажилчид зэрэг эмзэг бүлгийнхэн тус хороонд адил тэгш төлөөлөлтэй байж, шагналын ашиглалтыг ардчилсан байдлаар шийдэх боломж нөхцлийг бүрдүүлнэ.

2. БУБ олборлолтын газрынхаа хэмжээнд хүлээх хариуцлага

- БУБ олборлолтын газартаа ажиллаж буй бүх уурхайчныг бүртгэх үүрэгтэй.

БУБ-н олборлолтын талбайд уурхайчид зөвшөөрөлгүйгээр албан бусаар ажиллаж байгаа болон тэндээс явах эсвэл бүртгүүлэхээс татгалзах тохиолдолд ийм бүлэг хүмүүсийн бүртгэлийг мэдэж, зэрэг мэдээллээ тухайн бүлгийн тоон / уурхайчдын тоо, болон олборлолтын хэмжээ, амны тоо гэх мэт/ болон чанарын /олборлолтын байдал, улирлын нөлөө гэх мэт/ талаас тодорхойлж, олборлолтын газар зөвшөөрөлгүй ажиллаж байгаа хүмүүс байгааг БУБ сайн мэдэж байгааг харуулах шаардлагатай. Албан бусаар, бүртгэлгүй ажиллаж буй иргэдийн /уурхайчид/ хувьд шудрага олборлолын үйлдвэрлэлийн системд оролцохгүй.

- БУБ олборлолтын газартаа сургалт явуулах, боловсролын кампанит ажил хийх, байгууллагын бодлогыг танилцуулах замаар олборлолтын практик ажиллагааг сайжруулахыг хөхиүлэн дэмжинэ.
- БУБ хорт бодис, ялангуяа мөнгөн усны аюулгүй менежментийг хөхиүлэн дэмжиж олборлолтын талбайд зөвхөн Шударга олборлолтын стандартын дагуу мөнгөн ус ашиглахыг зөвшөөрнө.
- БУБ нь олборлолтын талбайдаа хүүхдийн хөдөлмөрийн аливаа тэвчишгүй хэлбэр, албадан хөдөлмөрийг зөвшөөрөх ёсгүй.

3. БУБ нь өөрийн чадавхи, боломжийн хэмжээнд тулгуурлан уурхайн практик ажиллагааг сайжруулах, орон нутгийн удирдлага болон бусад холбогдох бүлгүүдтэй хамтран орчин тойрныхоо нутгийн ард иргэдийн тогтвортой хөгжлийг идэвхтэй хөхиүлэн дэмжиж, уурхайтай шууд ба шууд бусаар холбоотой ард иргэдэд нөлөөлж буй асуудлуудад хяналт тавин, асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх хамтын хариуцлага хүлээж ажиллана. БУБ нь нутгийн ард иргэдийн тогтвортой хөгжлийг дэмжих ажилд идэвхтэй оролцох ёстой.

Бичил уурхайчдын багагүй хувь нь шилжин ирэгсэд байж болохыг харгалзан шинээр нүүж ирэгсдийг нутгийн иргэдийн бүлгийн нэг

хэсэг гэж үзэж, шилжин ирэгсдийн эзлэх хувь өндөртэй БУБ-ууд гэрчилгээ авах хүсэлт гаргаж болох бөгөөд нийт уурхайчин иргэдийн 51% гэсэн босгыг хүлээн зөвшөөрнө.

Аудитын хүрээ: Гэрчилгээ эзэмшигч БУБ энэхүү СТАНДАРТ-ын бүхий л шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд үүний биелэлтэд дээр дурдсан хариуцлагын түвшиний дагуу аудит хийх болно.

1.3 БУБ-ын олборлолтын талбай ба Шударга олборлолтын үйлдвэрлэлийн систем

Шударга олборлолтын алт ба дагалдах үнэт металл нь дан ганц БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системээс гаралтай байна.

БУБ түүний уурхайчдын (буюу бичил уурхайчид) эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй газруудад ашигт малтмал ашиглах эрхийг БУБ эзэмших эсвэл газрыг өмчилдөг, газрын эзэнтэй газар ашиглалтын гэрээ байгуулсан байна. БУБ –ын олборлолт явуулж буй бүх газраа, эсвэл нэг хэсгийг нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд оруулж болно. Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд орсон олборлолтын газар нь БУБ-ын бүрэн хяналтад байна.

Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд орсон газраас гадуур ашигладаг, БУБ-ын мэдэлд бүрэн ороогүй, гуравдагч талын боловсруулах цехүүдийг гэрээт байгууллагууд гэх бөгөөд хяналтын тусгай журам үйлчилнэ. Эрх бүхий алт боловсруулагчаас цааш өөр өөр зах зээлд зориулсан биетээр хянах боломжтой худалдааны боломжуудыг Шударга олборлолтын систем олгодог.

1.3.1 Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд оруулах ажиллагаа

БУБ нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системээ тодорхойлж баталгаажуулалтын гэрчилгээ авахаар өргөдөл гаргахын өмнө гэрчилгээжүүлэлтэд хамрагдах хүрээгээ тодорхойлсон байна.

БУБ бичил уурхайн аль талбай, ард иргэдийн бүлэг, бичил уурхайчид, боловсруулалтын нэгжүүд Шударга олборлолтын

нийлүүлэлтийн сувагт хамрагдаж, улмаар Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд орох, аль нь хамрагдахгүй, эсвэл зөвхөн үйлчилгээ үзүүлэгч байхыг тодорхойлно.

БУБ нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан бүх газартаа хуулиар эсвэл эрх зүйн баримт бичгээр олгогдсон бүрэн эрхтэй байх ёстой:

- БУБ буюу түүний бичил уурхайчид холбогдох хууль журмын дагуу газар эзэмших эрхтэй буюу эрх авсан, холбогдох гэрээ хэлцэлийг хийсэн байх
- БУБ буюу түүний бичил уурхайчид ашигт малтмал боловсруулах дотоодын байгууламж буюу үйлдвэрлэлийн хэрэгсэл эзэмшдэг байх (шаардлагатай бол).

Үйлдвэрлэлийн системийг дараахь үе шатаар тодорхойлно:

- БУБ-ын гишүүн **бүх уурхайчдын бүртгэлд** нь хамгийн багадаа доорх мэдээлэл орсон байна:
 1. Нэр
 2. Төрсөн он сар өдөр
 3. Биеийн байцаалт / иргэний үнэмлэхийн дугаар
 4. Харъяалагддаг байгууллага (нөхөрлөл, БУБ, хоршоо гэх мэт), ажлын хэсэг, уурхайн байрлал, эсвэл жижиг үйлдвэрийн нэр.
- **Олборлолтын газрын тойм зураг, бичгийн тодорхойлолтын хамт.** Тойм зургаар нутгийн ард иргэдийн бүлгийн тойм (нөхөрлөлүүдийн байршил), БУБ-н уурхайн талбай дахь олборлолтын талбайн байршил, уурхайн болон боловсруулах цехийн байршлийг зааж аль нь уг БУБ-ын Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт орсон, аль нь ороогүйг тодорхой харуулсан байна. Мөн Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувгийн нэг хэсэг боловч БУБ-ын хүрээнээс гадуур байгаа гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчдийг дүрсэлж бичих ёстой.

Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хувь хүмүүсийг оруулахдаа тухайн БУБ-ын дотоод дүрэм эсвэл журамд заасан зарчмуудыг баримтлах бөгөөд оруулах шалгууруудыг тодорхой зааж өгсөн байна.

Хэрэв Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд цорын ганц үйлдвэрлэлийн нэгж (тухайлбал, хэсэг бүлэг уурхайчин, уурхайн байрлал эсвэл боловсруулах үйлдвэр) орсон бол түүний хамрах хүрээнд ажиллаж буй бүх бичил уурхайчдыг Үйлдвэрлэлийн системд оруулах ёстой.

Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд тухайн нийлүүлэлтийн дотоод сувгийн төрөл бүрийн техник элемент, нэгжүүдийг хамруулан дүрсэлнэ. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй гуравдагч талын өмчлөлд буй болон ажиллуулж буй дэд бүтцийн (боловсруулах үйлдвэр гэх мэт) хувьд БУБ ямар түвшний эрх мэдэлтэй байж, хариуцлага хүлээж байгааг тодорхой дүрсэлнэ.

1.3.2 Шударга олборлолтын ердийн ба экологийн алт үйлдвэрлэлийн зэрэгцээ систем

Бичил уурхайчдынх нь зарим нь арай өндөр түвшний шаардлага бүхий Экологийн хувьд шударгаар олборлосон алт үйлдвэрлэдэг, зарим нь “ердийн” Шударга олборлолтын алт үйлдвэрлэдэг бөгөөд БУБ-дын хувьд нэг байгууллагад хоёр тусдаа Үйлдвэрлэлийн систем зэрэгцэн оршиж байж болох ба Үйлдвэрлэлийн хоёр систем хоёулаа Дотоод хяналтын эрүүл, бие даасан системтэй байж, Үйлдвэрлэлийн систем бүрийнхээ явцын хяналтыг тавихын зэрэгцээ уурхайн олборлолтын газар, уурхайчид, боловсруулах нэгжийн хувьд ямар нэг давхцал үүсэхээргүй байна.

1.3.3 БУБ-ын бичил уурхайчид, орон нутгийн байгаль орчны талаар хүлээх зайлшгүй үүрэг хариуцлага

Ихэнхи олон нийтийн БУБ-уудын мөн чанар нь Шударга олборлолтод оролцож бичил уурхайчин иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулахыг зорьдогт оршино.

БУБ-ууд **3-р түвшиний үүрэг хариуцлагын** хүрээнд дараах асуудлууд хамрагдана:

Үүнд

- Тухайн ард иргэдийн бүлэг дэх эмэгтэйчүүд, хүүхдүүдийн нөхцөл байдал,

- Тухайн ард иргэдийн бүлэг дэх хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлт,
- Тухайн ард иргэдийн бүлэг дэх мөнгөн усны менежмент,
- Нөлөөллийн нутаг дэвсгэр дээрх биологийн төрөл зүйл, ой модны хамгаалалт, усны зохистой ашиглалтын асуудал.

БУБ нь ХУУХ-ны Хариуцлагатай бичил уурхайн зарчмуудын дагуу энэхүү 3-р түвшиний үүрэг хариуцлагыг өөрийн чадавхид нийцүүлэн идэвхтэй гүйцэтгэдэг бөгөөд дээрх асуудлуудыг шийдвэрлэх үйл ажиллагаанууд нь БУБ, түүний Шагналын хорооны Шударга олборлолтыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийн төлөвлөгөөний нэг салшгүй хэсэг байх ёстой буюу БУБ-ын бусад арга хэрэгсэлээр дамжин илэрхийлэгдэх ёстой. Эдгээр үйл ажиллагаа нь орон нутгийн удирдлагын чиг үүргийг орлох, нөхөх байдлаар биш, түүнд нэмэлт болж хэрэгжих ёстой.

1.4 Бүтээгдэхүүний цар хүрээ

СТАНДАРТ-д Шударга олборлолтын гэрчилгээ бүхий бичил уурхайгаас олборлосон алтыг хамруулах бөгөөд дараах олборлолтын газрууд ихэвчлэн байдаг.

- Үндсэн ордын гадаргуугийн эсвэл гүний судал бүхий уурхай, гол төлөв том, дунд хэмжээний уурхайн компаниудийн орхисон газар байдаг,
- Жижиг судал бүхий илрэлүүд,
- Голын эрэг, сайр, дэнж газрууд дахь өнгөн хөрсний буюу шороон ордууд,
- Хүдрийн хаягдал буюу хаягдлын овоолго,
- Хөрс хуулалтын үлдэгдэл.

СТАНДАРТ-ын хамрах хүрээнд алт буюу дагалдах металлийг техник ашиглан механикаар ухаж гаргах ажиллагааг оруулахгүй бөгөөд цэвэр гар аргаар ухах ажиллагааны дараах нөхцлүүд бүгд хангагдсан тохиолдолд л хамруулах боломжтой:

1. *Цэвэр гар ажиллагаатай:*

- Ухагч машины сорох хоолойн диаметр 4 инчээс хэтрэхгүй дээд хүчин чадалтай байх.
- Олборлолтын талбайд ажиллаж буй нийт ухагч машины дундаж тоо гол мөрний 1 км тутамд, нуур, далай тэнгисийн усны 1 га тутамд 1-ээс хэтрэхгүй байх.

2. *Байгаль орчинд үзүүлэх нөлөө бага:*

- Ухагч машинаас үүссэн усны бохирдол буюу булингар (гр/л) (урсгалаас доош 10 метрт хэмжихэд) улирлын чанартай байгалийн булингарын бүртгэгдсэн хамгийн дээд хэмжээнээс хэтрэхгүй байх.

3. *Байгаль орчинд ямар нэг хорт бодис ялгаруулахгүй:*

- Түлшний сав, хөдөлгүүр, насос нь түлш шатахууны үлдэгдэл асгарахаас сэргийлсэн хамгаалалтын хэрэгсэлээр тоноглогдсон байх. (Ухагч машины тавцан дээрх түлш шатахууны үлдэгдлын тухай стандарт шаардлагууд).
- Химийн хорт бодис ашиглахыг хориглосон газарт ухагч машины тавцан дээр хүн оршин суух газартай адилтгах хэмжээний стандартын шаардлагууд үйлчилнэ.

1.4.1 Дайвар бүтээгдэхүүн

Мөн СТАНДАРТ-д алт нь мөнгө, цагаан алт (цагаан алтны бүлгийн металлууд) гэх мэт бусад дагалдах үнэт металлын хамт олдож болохыг харгалзан үздэг бөгөөд гэрчилгээжсэн алтны хамт олдсон эдгээр үнэт металлд ч бас Шударга олборлолтын гэрчилгээ олгож болно. Үнэ, Шагналын хэмжээг цэвэр алтны агууламжид үндэслэн тогтооно.

1.4.2 Шударга олборлолтын алтны тусгай бүтээгдэхүүний тодорхойлолт

Шударга олборлолтын алт гэж энэхүү СТАНДАРТ-ын шаардлагын дагуу БУБ-н олборлосон ашигт малтмалд эсвэл үйлдвэрлэсэн металлд янз бүрийн хайлш, хольц хэлбэрээр агуулагдаж буй “алт” хэмээх химийн цэвэр элемент (Au)-ийг хэлнэ.

Экологийн шударга олборлолтын алт гэж БУБ-аас Экологийн алтны нэмэлт шаардлагын дагуу үйлдвэрлэсэн Шударга олборлолтын алтыг хэлнэ.

100% цэвэр алт гаргах нь техникийн болон эдийн засгийн хувьд боломжгүй учраас дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн сорьцийн стандарт болох Лондоны алтны бирж (ЛАБ)-ийн СТАНДАРТЫГ практикт хэрэглэдэг. ЛАБ-ын СТАНДАРТ-ын дагуу хүлээн зөвшөөрөгдөх хамгийн доод сорьц бол мянган нэгж тутамд 995.0 нэгжийн агууламжтай байх явдал бөгөөд сорьцийг дөрвөн оронтой тоогоор хэмждэг.

1.4.3 Шударга олборлолтын мөнгө, цагаан алтны тусгай бүтээгдэхүүний тодорхойлолт

Шударга олборлолтын мөнгө гэж олборлосон ашигт малтмалд эсвэл металлд янз бүрийн хайлш, хольц хэлбэрээр агуулагдаж буй “мөнгө” хэмээх химийн цэвэр элемент (Ag)-ийг хэлнэ.

Шударга олборлолтын цагаан алт гэж олборлосон ашигт малтмалд эсвэл металлд янз бүрийн хайлш, хольц хэлбэрээр агуулагдаж буй платинум буюу “цагаан алт” хэмээх химийн цэвэр элемент (Pt)-ийг хэлнэ.

Экологийн Шударга олборлолтын мөнгө, Экологийн Шударга олборлолтын цагаан алт гэж БУБ-аас Экологийн цэвэр алтны нэмэлт шаардлагын дагуу үйлдвэрлэсэн мөнгө, цагаан алтыг хэлнэ.

1.5 Газар зүйн хамрах хүрээ ба үл хамрагдах газрууд

Шударга олборлолтын үйлдвэрлэгч орнуудын газар зүйн хамрах хүрээнд Латин Америк, Карибийн тэнгис, Африк, Ази, Далайн бүс нутгийн Хөгжлийн албан ёсны тусламж хүртэгч орны жагсаалтад багтсан бага, дунд орлоготой орнууд багтдаг¹.

¹Ази, Далайн бүс нутгийн Хөгжлийн албан ёсны тусламж хүртэгч орны жагсаалтыг ХУУХ-ны вэб сайтаас

Нэмүү өртгийн үйлдвэрлэл, хэрэглээний газар зүйн хамрах хүрээний хувьд дэлхийн улс орнуудыг бүхэлд нь хамарсан байна.

Энэхүү хүрээнд дараах газрууд үл хамрагдана:

а) *Хөдөө аж ахуйн болон бичил уурхайн үйл ажиллагааны хооронд зөрчилдөөнтэй газрууд.*

б) *Тусгай хамгаалалттай газрууд ба экологийн эмзэг системүүд*

б1) *Байгаль орчны болон архелогийн хамгаалалттай газар:* Үүнд үндэсний хууль тогтоомжийн дагуу уул уурхай эрхлэхийг зөвшөөрөөгүй, тусгай хамгаалалттай бүхий л газрууд, түүний дотор холбогдох эрх бүхий байгууллагаас хасахаар заасан завсрын бүсүүд хамаарна. БУБ-ууд тухайн газарт байгаль орчны эрх бүхий байгууллагын хяналт дор 10-аас дээш жил ажилласан эсвэл тэдний үйл ажиллагаа хамгаалалтын зорилтуудтай зэрэгцэн хэрэгждэг, мөн олборлолт явуулах эрх, байгаль орчны зөвшөөрөл авснаа харуулж чадсан тохиолдолд онцгой нөхцлөөр хоригоос чөлөөлөгдөж гэрчилгээ авах өргөдөл гаргаж болно.

б2) *Эмзэг экосистем:* ХУУХ нь “Түр хасагдах газруудыг (ТХГ) тодорхойлох журам ба тайлбар баримт бичигт” заасны дагуу уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчинд онцгой аюул занал учруулж болзошгүй байгаль орчны хувьд эмзэг газруудыг (үндэсний хууль тогтоомжоор хамгаалаагүй) тогтоож болно.

в) *Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэл бүхий газрууд:*

Энэ хязгаарлалт нь “Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэл бүхий газраас олборлосон ашигт малтмалын нийлүүлэлтийн хариуцлагатай сүлжээтэй зүй зохистой ажиллах ЭЗХАХБ-ын удирдамж”-ийн “Алтны тухай нэмэлт” хэмээх 1 дүгээр хавсралтад заасан зөрчил, мөргөлдөөнтэй, эрсдэл ихтэй газар хэмээн “улаан туг” зоосон бүхий л газруудад хамаарна.

1.6 Бүтэц

СТАНДАРТ-д зорилго бүхий оршил хэсэг, тавигдах шаарлага зарчимуудыг нэр томъёоны хувьд зааж өгсөн хэсэг, шаардлага бүрийн дагаж мөрдөх хугацаа (жил), аудитын хамрах хүрээ, БУБ-ын хүлээх үүрэг хариуцлагын 3 түвшинг (**Шударга олборлолтын үйлдвэрлэлийн систем/ БУБ/ Нутгийн ард иргэд**) зааж өгсөн байна.

1.7 Лавлах материалууд

Шударга олборлолтын стандартыг тогтоохдоо олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, конвенциудыг харгалзан үзсэний дотор хамгийн өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн олон улсын стандарт болох Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) стандартыг харгалзсан.

Үйлдвэрлэгч байгууллагуудыг үндэсний хууль тогтоомжийг ямагт дагаж мөрдөхийг уг СТАНДАРТ шаарддаг.

“Босго” түвшний шаардлагууд нь үндэсний хууль тогтоомжоос хэтрэхгүй байх зорилготой бол, үндэсний хууль тогтоомжоос дээгүүр олон улсын стандарт, конвенциудыг дагаж мөрдөх шаардлагыг “Босго” биш, “Шат ахисан” түвшний шаардлага гэж үздэг. Хэрэв аль нэг шаардлага дээрхтэй нийцэхгүй байвал гэрчилгээ олгогчийн зүгээс уг шаардлагыг “Шат ахисан” түвшний шаардлага гэж үзэн тохируулга хийх хангалттай хугацаа олгоно.

СТАНДАРТ-ын шаардлагууд хууль эрх зүйн шаардлагуудаас өндөр тохиолдолд хууль эрх зүйн шаардлага нь СТАНДАРТ-ын шаардлагуудаа тодорхой хугацаагаар орлох бөгөөд гэрчилгээжүүлэлтийн дараагийн 3 жилийн мөчлөгт СТАНДАРТ-ын шаардлагууд хүчинтэй үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, дагаж мөрдөх шаардлагыг 3 дахь жил хүртэл хойшлуулана гэсэн үг.

Энэхүү СТАНДАРТ нь Хариуцлагатай уул уурхайн тухай ХУУХ-ны зарчмуудыг дагаж мөрддөг бөгөөд дараах зарчимууд дээр суурилдаг.

ХАРИУЦЛАГАТАЙ БИЧИЛ УУРХАЙН ЗАРЧМУУД²

1. Мянганы хөгжлийн зорилт ба Тогтвортой хөгжлийн тунхаглал³
2. Хууль ёсны байдал
3. Хүний эрх
4. Зохистой ажил
5. Бичил уурхайчин иргэдийн амьдралын чанар ба хүний тогтвортой хөгжил
6. Байгаль орчны хариуцлага
7. Жендэрийн тэгш байдал
8. Олон янзын соёлын орчин⁴
9. Зэвсэгт мөргөлдөөнийг үл дэмжих

Тодорхойлолт: Энэхүү СТАНДАРТ-д хэрэглэгдсэн бүх нэр томъёог уг Нэр томъёоны тайлбарт заасан тодорхойлолтын дагуу тайлбарлаж ойлгох ёстой.

Хэрэгжилт: Гэрчилгээ олгогч байгууллага аудит хийх болон гэрчилгээжүүлэх шийдвэр гаргахдаа энэхүү СТАНДАРТ-ын үг хэллэг, өгөгдсөн зорилт, заавар удирдамжийг чанд баримтлана. Стандартын хэрэгжүүлэгчийн зүгээс маргаан гаргасан тохиолдод гэрчилгээ олгогч тухайн СТАНДАРТ яг ямар санаа зорилготой талаар стандарт тогтоогчтой зөвлөлдөх ёстой.

Хэрэглээ: Энэ бол Бичил уурхайгаас олборлосон алт ба дагалдах үнэт металлын Шударга олборлолтын стандартын 2.0 хувилбар юм. Энэхүү хувилбар 2014 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

²Алтан судал: Хариуцлагатай бичил уурхайн гарын авлага. Бичил уурхайн тухай ХУУХ-ны цуврал, 2008.

³Шударга олборлолт нь Мянганы хөгжлийн зорилтууд, Тогтвортой хөгжлийн талаарх Иоханнесбургийн тунхаглал болон Хариуцлагатай бичил уурхайн тодорхой хэдэн зарчмуудыг дагаж мөрдөх үүрэг амлалт авсан.

⁴ОУХБ-ын 169-р конвенцийн дагуу орон нутгийн соёлыг хүндэтгэн нутгийн иргэдтэй зөвлөлдөж, тухайн газар нутагт уурхайн үйл ажиллагаа, худалдаанаас үзүүлэх нөлөө ба хүртэх ашиг тусын талаар нутгийн ард иргэд, тэдний уламжлалт удирдлагатай ярилцаж тохиролцоонд хүрэх хэрэгтэй.

Шударга олборлолтын стандарт нь ХУУХ-ны 2006 оны “Шударга худалдааны алтны Тэг стандарт” болон 2010 онд гарсан “Бичил уурхайгаас олборлосон алт, түүнийг дагалдах мөнгө, цагаан алтны шударга худалдаа, шударга олборлолтын стандарт”-аас үүсэлтэй болно.

Гэрчилгээ хэдийн авчихсан БУБ, операторуудийн шилжилтийн хугацаа дээрх өдрөөс эхлэн 1 жил байна. Энэ хугацаанд тухайн БУБ эсвэл оператор нь уг СТАНДАРТ-ын 1.1 эсвэл 2.0 хувилбарын аль нэгийг сонгож болно.

Шударга олборлолтын Шагналын төлбөр, Шударга олборлолтын хөгжлийн төлбөрийн хувьд ямар нэг шилжилтийн үе үйлчлэхгүй. Шагналын түвшинд ямар нэг зохисгүй өөрчлөлт гаргахгүйн тулд, мөн шагналын шинэ хэмжээ 4000 ам.доллар/кг нь өмнөх хэмжээ 2013 оны 12 сард тогтоосон Лондоны алтны зах зээлийн дундаж үнийн 10 хувьтай маш ойролцоо гэж үзсэн тул Шударга олборлолтын Шагнал ба хөгжлийн хураамжийн шинэ хэмжээ 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс бүх гүйлгээнд хэрэглэгдэж эхэлнэ.

Хувилбар 1.1 ба 2.0-н хоорондох төлбөрийн тооцооны гүйлгээний чанартай бусад ялгааны хувьд: Хэрэв шилжилтийн үеийн үеэр худалдагч, худалдан авагч талууд өөр СТАНДАРТ-ын хувилбар дээр ажиллаж байгаа тохиолдолд тэд гүйлгээндээ аль СТАНДАРТ-ын хувилбарыг удирдлага болгохоо харилцан тохирч болно. Хэрэв ямар нэг тохиролцоо, гэрээ байхгүй бол худалдагчийн (үйлдвэрлэгчийн) хувилбар гүйлгээнд давамгайлна.

1.8 Нэмэлт өөрчлөлтүүдийн хяналт

ХУУХ нь тус холбооны Стандарт тогтоох журам болон уурхайчид, худалдаачид, мэргэжлийнхэн, ТББ-уудын төлөөлөгчдөөс бүрдсэн Шударга олборлолтын стандартын хорооны Ажлын удирдамжид заасны дагуу уг СТАНДАРТ-д өөрчлөлт оруулах эрхтэй байна. СТАНДАРТ-ын шаардлагуудыг нэмж, хасч эсвэл өөрчилж болно. Гэрчилгээжүүлэлт нь уг СТАНДАРТ-ыг дагаж мөрдөх нөхцлийг бүрдүүлнэ.

2.1 Зорилго

Ерөнхий шаардлагын хүрээнд гэрчилгээжүүлэлт ба уг СТАНДАРТ-н хамрах хүрээтэй холбоотой шаардлагуудыг харуулахад оршино.

2.2 Гэрчилгээжүүлэлтэнд хамрагдах

Шудрага олборлолтын гэрчилгээжүүлэлтэнд бичил уурхай эрхлэгчидын хувьд ямар нэг БУБ-тай бол оролцож болох бөгөөд стандартын босго шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Гэрчилгээжүүлэлтэнд анх хамрагдахдаа БУБ өргөдлийн асуулга бөглөж, шаардлагатай баримт бичгийн хамт ХУУХ-д илгээх замаар “бичил уурхайн” шинж чанараа баталгаажуулж таниулах шаардлагатай. Өргөдлийн маягт бүхий асуулга нь ХУУХ-ны вэб сайтад тавигдсан байдаг бөгөөд өргөдөл гаргагч уг СТАНДАРТ-ын шаардлагын дагуу БУБ-д тооцогдож болох эсэхийг тогтооход стандартын хамрах хүрээний⁵ шалгуур үзүүлэлтийг ашиглаж болно.

БУБ нь өөрийн үйл ажиллагаа явуулдаг газар болон гэрээт газарт стандартын дагуу хариуцлагын түвшний⁶ дагуу аудит хийлгэж, гэрчилгээжүүлэгч байгууллагын хүссэн мэдээллийг гаргаж өгөх ёстой.

БУБ нь гэрчилгээжүүлэлттэй холбоотой бүх асуудлыг хариуцаж ажиллах хүн томилох бөгөөд уг хүн нь гэрчилгээ олгогч байгууллага болон ХУУХ-ыг холбоо барих хаяг болон бусад чухал шаардлагатай мэдээллээр байнга хангаж байх үүрэгтэй.

⁵ХУУХ –ны Хувилбар 2.0, Бүлэг 0.2.1 – “Бичил уурхайн хамрах хүрээ”

⁶ХУУХ –ны Хувилбар 2.0, Бүлэг 0.2.2 – “Байгууллагын хамрах хүрээ”

2.3 Гэрчилгээжүүлэлтийн хамрах хүрээ

Энэхүү СТАНДАРТ нь бичил уурхайчин ард иргэдийн бүлэгт тулгуурласан байж болох бүхий л боломжит төрлийн байгууллагуудаас бүрдсэн, уурхай эрхэлж буй ард иргэдийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад зорилго бүхий Бичил уурхайн байгууллагад (БУБ) чиглэнэ. Гэрчилгээ эзэмшигч БУБ уг стандартын бүхий л шаардлагыг ямагт дагаж мөрдөж ажиллах үүрэгтэй. Харин БУБ-ын 1 дүгээр түвшний үүрэг хариуцлагад нийцсэн, уг стандартын дагаж мөрдөх бүхий шаардлагыг хангасан Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системээс үйлдвэрлэсэн алтыг Шударга олборлолтын алт хэмээн гэрчилгээжүүлэн худалдаж болно.

БУБ-ын гэрчилгээжүүлэлтийн эхний жилд босго түвшиний шаардлагуудыг хангаж ажиллах нь чухал.

Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийг:

- Аль уурхайчид Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд орсон, аль нь ороогүйг тодорхойлсон БУБ-ын **бүх уурхайчдын иж бүрэн бүртгэл**ээр дамжуулан тодорхойлно.
- **Бичгээр дүрсэлсэн тодорхойлолт ба тойм зураг.** Уурхайн газар нутаг, нутгийн ард иргэдийн бүлгийн тойм зургаар БУБ-н уурхайн талбай дахь олборлолтын талбай, уурхайн болон боловсруулах цехийн байршлийг зааж аль нь уг БУБ-ын Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт орсон, аль нь ороогүйг тодорхой дүрслэн харуулсан байна. Мөн Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувгийн нэг хэсэг боловч БУБ-ын хүрээнээс гадуур байгаа гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчдийг дүрслэж оруулах ёстой.

БУБ-ын хувьд Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт гадны үйлчилгээ үзүүлэгчид оролцуулах тохиолдолд тэднээс БУБ гарал үүслийн хяналтын шаардлага болон хууль эрх зүйн шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэгч сонгохын тулд бүхий л шаардлагатай зүйлсийг хийснээ харуулах ёстой.

Хэрэв БУБ Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувгийн хэсгүүдэд ямар ч хяналт тавих боломжгүй бол (тухайлбал, гуравдагч

талын өмчийн боловсруулах цех, алт бариулах цех) тэдгээрийг гадны үйлчилгээ үзүүлэгчид гэж үзнэ. Хэрэв Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн (ШОҮС) нэг хэсэг болсон уурхайчид эдгээр цехийг өмчилж байгаа (нилээд их хувь эзэмшин хамтран өмчлөгч эсвэл хууль ёсны цөөнх) бол тэднийг гадны үйлчилгээ үзүүлэгч гэж үзэж болохгүй бөгөөд Үйлдвэрлэлийн системд оруулж, бүх шаардлагуудыг дагаж мөрдөх шаардлагатай. ШОҮС-д орох БУБ болон бүх хуулийн этгээдүүд, байгууллагууд холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоосон хууль ёсны, ил тод бүтэцтэй, санхүүгийн хяналттай байна.

БУБ-ын хүрээнд ажиллаж байгаа уурхайчдын дийлэнх нь (50%-иас дээш) иргэдийн бүлэгт тулгуурлан гар аргаар ашигт малтмал олборлогч бичил уурхайчид байх ёстой. Уурхайн олборлолтыг тэд өөрсдөө болон гэр бүлийн хамтаар явуулна.

БУБ-ын эзэд, гишүүд, эзэмшигчид өөрсдөө уурхайн эрхлэгч иргэдийн бүлгийн нэг хэсэг байх бөгөөд олборлолтын үйл ажиллагаанд гар бие оролцож БУБ-ын санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг явуулна. Харин үйлдвэрлэлийн чанартай том уурхайн хөрөнгийн хувьцаа эзэмшигч биш байна.

БУБ нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд (ШОҮС) орохыг хүссэн, энэхүү СТАНДАРТ-ын шаардлагуудыг дагаж мөрдөхөд бэлэн байгаа аливаа бүлэг, хувь хүнийг системд оруулах, үл оруулах тухай тодорхой заасан дүрэм журамтай байх бөгөөд үл ялгаварлан гадуурхах үзэл баримтлалыг дүрэм журманд тусгаж, дагаж мөрддөг байна.

Зөвхөн ШОҮС-д орсон уурхайчид, олборлолтын талбайгаас ШО-ын алт, алтны хүдэр, баяжмал, хаягдал хүдэр үйлдвэрлэж болно. ШОҮС-д ороогүй уурхайчид, олборлолтын талбайгаас нийлүүлсэн алт, алтны хүдэр, баяжмал, эдийн засгийн үнэ цэнэ бүхий хаягдал хүдрийг ШО-ын алтнаас тусдаа байлгах ёстой бөгөөд ШО-ын алттай хамт борлуулахыг хориглоно. Мөн БУБ нь ШО-ын нийлүүлэлтийн сувагт оруулсан бүтээгдэхүүн, борлуулалтын хэмжээгээ хянаж чадах хэмжээний Дотоод хяналтын системтэй (ДХС) байж, түүнийгээ

ШОУС-д ороогүй уурхайчид, уурхайн газар, боловсруулсан ашигт малтмал, алт эсвэл хаягдал хүдрээс сайтар тусгаарласан байна.

2.4 БУБ-ын ерөнхий шаардлага

БУБ-ын тусгай үүрэг хариуцлага: Тусгай үүрэг хариуцлагын хүрээнд ШО-ын гэрчилгээ авахыг хүссэн уурхайчид, ШОУС-д хамрагдах байгууллагууд олборлолтын болон арилжааны үйл ажиллагаагаа албан ёсны болгож, татвар хураамжаа холбогдох эрх бүхий байгууллагад төлөх ёстой.

Мөн Шударга олборлолтын гэрчилгээжүүлэлтэд оролцсон хариуцлагатай БУБ-ууд нь үндэс угсаатны бүлэг, малчид, тариаланчид гэх мэт нутгийн иргэдийн бусад бүлгийн шаардснаар байгалийн нөөцөд хохирол учруулахгүй, тухайн орон нутгийн хууль ёсны болон уламжлалт эрх бүхий удирдах байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа, зөрчлийн менежментийн үр дүнтэй механизм хэрэгжүүлж байгаагаа нотлон харуулахаас гадна БУБ буюу түүний уурхайчид Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд орсон бүх газартаа газар холбогдох хууль журмын дагуу зөвшөөрөлтэй байх ёстой.

БУБ, түүний уурхайчдын орлогыг ямар нэг хууль бус ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнийг санхүүжүүлэх, дэмжихэд шууд ба шууд бусаар ашиглах ёсгүй.

ШОУС-д хамрагдах байгууллагууд нь Хүний эрх, байгаль орчны асуудлаар өргөдөл гомдол барагдуулах, түүний дотор зохих ёсоор шалгаж магадлах журамтай байж, БУБ нь орон нутгийн түвшинд шийдэгдээгүй гомдлын талаар ХУУХ-нд мэдээлж байх ёстой.

БУБ нь эхний жилдээ өөрийн 2-р түвшний хариуцлагын хүрээнд тухайн олборлолтын газрын бүх уурхайчид Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд ороогүй тохиолдолд уурхайн олборлолтын талбайн хэмжээнд хариуцлагатай бичил уурхайг идэвхтэй дэмжин сурталчилаж ажиллана.

БУБ нь гэрчилгээжүүлэлтэнд хамрагдсан 3 дахь жилээс Уурхайн нутаг дэвсгэрт орон нутгийн тогтвортой хөгжлийг төлөвлөх, хөхиүлэн дэмжихэд идэвхтэй үүрэг гүйцэтгэж ажиллана. БУБ нь эргэн тойрны нутаг орон, түүний дотор уул уурхайн БУС газар нутаг, байгууллага, хүмүүсийн төлөө 3 дугаар түвшний үүрэг хариуцлага хүлээн мөн Шударга олборлолтын үндсэн зарчмуудын хэрэгжилтэд ахиц дэвшил гаргах үүрэг хүлээнэ.

БУБ-уудын идэвхтэй, хамтын хариуцлага бүхий тодорхой үйл ажиллагаа явуулж, хяналт тавих хамгийн эмзэг чиглэлүүд:

- Нутгийн иргэдийн доторх эмэгтэйчүүд, хүүхдүүдийн байдал
- Нутгийн иргэдийн доторх хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн асуудал
- Нутгийн иргэдийн доторх мөнгөн усны менежментийн асуудал
- Нөлөөллийн бүс дэх биологийн төрөл зүйл, ой, усны хамгаалалт

Үүнээс гадна байгаль орчны (ой, ус) нөөцийг тогтвортой удирдах, хяналт тавих чиглэлээр орон нутгийн иргэдийн бүлгүүд, эрх бүхий газруудтай хамтран ажиллах бүхий л боломжит үйл ажиллагааг явуулна.

БУБ-ын хүрээнд гарал үүслийг хянах боломж: Шударга олборлолтын алтны жинхэнэ гарал үүслийг шалгаж тогтоох боломжтой байх, улмаар операторууд зөвхөн Шударга олборлолтын сувгаар худалдаж авсан бүтээгдхүүнээ борлуулах боломжтой байлгах, операторууд болон хэрэглэгчдийг хамгаалах зорилготой.

Гарал үүслийн дагалдах бичиг баримтыг шалган тухайн алтны үйлдвэрлэгч хүртэл хөөн үзэх, тухайн бүтээгдэхүүн Шударга олборлолтын бус алтнаас биет байдлаар тусдаа, ялгагдахуйц байх нөхцлийг бүрдүүлнэ.

Бичиг баримтаар гарал үүслийг хянах боломжтой байх шаардлага ямагт тавигдана. Бичиг баримтаар гарал үүслийг баталгаажуулах нь БУБ-ууд олборлон гаргасан алтыг худалдан авсны үр шимийг эдгээр баталгаажсан байгууллагуудад шууд хүртэх юм гэдэг баталгаа болно. Нөгөө талаар гарал үүслийг баталгаажуулсан ШОУС-д орсон талууд ШОУС-ийн алтны

худалдааны үр шим, шагналыг хүртэх нөхцөл бүрдэх юм.

Шударга олборлолтын алтны хувьд БУБ-ын гарал үүслийг хянахтай холбоотой зардал нь Шагналаар дамжин хүртэх үр ашигаас нь хэтрэхгүй байгаа тохиолдолд биетээр гарал үүслийг хянах боломжийг хангах шаардлагатай.

БУБ нь ашигт малтмалын гарал үүслийг дотооддоо хянах боломжийг хангахын тулд Үйлдвэрлэлийн системдээ Дотоод хяналтын үр дүнтэй систем нэвтрүүлэх үүрэгтэй.

Иймд БУБ нь Дотоод хяналтын систем (ДХС) хэрэгжүүлж тухайн хүдэр, баяжмал, эцсийн бүтээгдэхүүний гарал үүслийг нотолж ажиллах нь чухал.

Ашигт малтмалын боловсруулалтад гуравдагч талын өмчлөлийн тоног төхөөрөмж түрээслэх, хөлслэх, эсвэл ашигт малтмалын боловсруулалт, хагас боловсруулсан бүтээгдэхүүн болгож баяжуулах зорилгоор гуравдагч талын гүйцэтгэгч гэрээгээр ажиллуулах тохиолдолд алтанд биет хяналт тавих ажлыг бүхий л боломжит нөхцөлд хийх ёстой.

Биет хяналтын шаардлагыг бүрэн дүүрэн биелүүлэхэд харьцангуй их нэмэлт зардал гарч байгаа нөхцөлд л тухайн БУБ-ыг уг шаардлагаас чөлөөлж болно. Гэхдээ Экологийн Шударга олборлолтын алтны хувьд чөлөөлөгдөх асуудал байхгүй. Гэрээт үйлчилгээ үзүүлэгчдэд (боловсруулагчид гэх мэт) биет аудит хийх бөгөөд уг ажлыг БУБ хариуцна.

Хоёр буюу түүнээс дээш тооны гэрчилгээтэй үйлдвэрлэгчээс авсан хоёр буюу түүнээс дээш тооны баталгаажсан хэмжээ бүхий ашигт малтмал буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг хамт боловсруулах зорилгоор нэгтгэх, холих, нийлүүлэхийг зөвшөөрнө. Гэхдээ энэ нь энгийн алтыг экологийн алттай холих асуудал биш юм. Энгийн алтыг энгийн алттай, экологийн алтыг экологийн алттай холих асуудал юм.

Экологийн алт нийлүүлэх гэрчилгээтэй БУБ-ууд гарал үүсэлд биет байдлаар хяналт тавих шаардлагыг цаг ямагт чанд мөрдөх ёстой.

БУБ дахь жендэрийн тэгш байдал ба үл ялгаварлал: Энэхүү СТАНДАРТ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал дахь ялгаварлан гадуурхалыг устгах тухай хэсгийг⁷ баримталдаг. БУБ-ууд үл ялгаварлан гадуурхах зарчмийг өөрийн дүрэм, журамд (үндсэн хууль, дотоод журам, дотоод бодлогууд) тусган баталгаажуулж, мөрдөж ажиллах шаардлагатай.

БУБ-ын хувьд ШОҮС-д оруулах ба үл оруулах дүрэм нь ил тод (ямар ч сонирхсон тал авч үзэх боломжтой) байж, зорилго, зорилтод нь нийцсэн биш бол яс үндэс, арьсны өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, ДОХ-ын халдвар, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, нас, шашин, улс төрийн үзэл бодол, хэл, өмч, үндэстэн, үндэсний ба нийгмийн гарал үүслээр ялгаварлахыг хориглосон байна. Мөн ШОҮС болон БУБ-ын үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоо, сонгох, сонгогдох эрх, зах зээлд хүрсэн байдал, сургалтад хамрагдах боломж, техникийн дэмжлэг болон бусад ашиг тус, үүрэг хариуцлагаар ялгаварлан гадуурхах ёсгүй.

Эмэгтэй уурхайчдын байгууллага, нутгийн уугуул уурхайчдын байгууллага болон түүнтэй ижил төстэй байдлаар нийтлэг шинж чанар нь нийтлэг хөгжлийн зорилгоо тодорхойлдог байгууллагуудын гишүүнчлэлийн ялгавартай байдлыг ялгаварлан гадуурхсанд тооцохгүй.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд 3 жилээс нийгмийн эмзэг хэсэг, цөөнхийн бүлгүүдтэй холбоотой хөтөлбөрүүд хэрэгжүүлж тухайн байгууллагад эдгээр бүлгийн эзлэх байр суурийг дээшлүүлэх, ялангуяа ажилд орох, сургалтад хамрагдах, Шагналын хорооны гишүүнээр элсэх боломж олгох, эмэгтэйчүүдийн адил тэгш төлөөллийг хангах талаар зохих арга хэмжээ авсан, эмэгтэй уурхайчид, цөөнхийн бүлгүүд тухайн байгууллага дах ашигт малтмалын нөөц, технологийн шинэчлэлийн үр шимийг адил тэгш хүртэх боломжтой байх ёстой.

⁷Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд “хүнийг яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрөлт болон бусад байдлаар ялгаварлахыг” хориглодог

2.5 Байгаль орчны хамгаалалт

СТАНДАРТ-ын бичил уурхайг байгаль орчны хариуцлагатай байдал, байгаль орчныг аажмаар сайжруулах чиглэлд хөтлөх зорилгын хүрээнд Шударга олборлолтын байгаль орчны шаардлагууд нь бичил уурхайгаас байгаль орчинд учруулах томоохон эрсдэлүүд, сөрөг нөлөөг аль болох шат дараалан багасгаж бууруулахад зорьж байна.

СТАНДАРТ-ын байгаль орчны хамгаалалтын хүрээнд дараах үндсэн 3 зүйлд дээр голчлон шаардалгуудыг тавиж байна.

- Хот бодисын менежмент
- Экосистемийн хамгаалалт
- Экологийн алт, цагаан алт, мөнгө

Шаардлагуудын хүрээнд бичил уурхайчдад тулгардаг, хүний болон капиталын нөөцөө харгалзан үзвэл богино эсвэл дунд хугацаанд бодитойгоор хэрэгжүүлж болох байгаль орчны тулгамдсан асуудлуудыг онцлон авч үздэг. Мөн олноор хошуурсан олборлолт болон байгаль орчны хувьд эмзэг газруудад халдахаас зайлсхийх боломж олгохоос гадна мөнгөн ус, цианид үл хэрэглэх, экосистемийн унаган төрхийг нөхөн сэргээхэд зориулсан Экологийн нэмэлт шагналыг урамшуулал болгон олгодог.

Шударга олборлолтын Шагнал нь хариуцлагатай уурхайн практикийг дагаж мөрдсөний төлөө олгох “шагнал” төдийгүй хөгжлийг бүтээхэд шаардлагатай хөрөнгөөр уурхайчдыг хангах хэрэгсэл юм.

2.5.1 Хорт бодисын менежмент

Мөнгөн ус, цианидын хэрэглээг нэн даруй, бүрэн зогсоох нь Шударга олборлолтын алтны хувьд хэрэгжих боломж муутай нөхцөл юм. СТАНДАРТ-д байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг багасгасан хариуцлагатай практик, технологиуд хэрэглэх замаар мөнгөн ус, цианидын хэрэглээг шат дараалан бууруулж, хамгийн бага хэмжээнд хүргэх чиглэлд БУБ-дад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна. Энэхүү СТАНДАРТ нь Мөнгөн усны тухай

Минаматагийн конвенцийг баримталж, уурхайчид дараахь үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаарддаг:

- 1) Хүдрийг бүхэлд нь мөнгөн усаар бариулах,
- 2) Бариулсан нэгдэл буюу боловсруулсан нэгдлийг ил шатаах,
- 3) Мөнгөн усны нэгдлийг хүн оршин суудаг орчинд шатаах,
- 4) Мөнгөн усны нэгдэл бүхий шаар, хүдэр, хаягдал уснаас мөнгөн усыг эхэлж ялгаж авалгүйгээр цианидаар угаах.

СТАНДАРТ-ын дагуу таталцалын аргаар алт угааж, мөнгөн ус, цианид хэрэглэхээ больсон, уурхайгаас экологид учрах хохирлыг хамгийн бага хэмжээнд хүртэл багасгаж чадсан БУБ-уудад Шударга олборлолтын шагнал дээр нэмж Экологийн шагнал олгож байгаа болно.

Бичил уурхайд мөнгөн ус, цианид хэрэглэхийг хориглодог хуультай улс оронд тухайн улсын хууль тогтоомж давуу хүчтэй үйлчилнэ.

Хэрэв мөнгөн усгүй технологи гарсан, тухайн бүсийн ижил төстэй орд газар ажиллаж буй бусад уурхайчид амжилттай туршсан тохиолдолд мөнгөн усгүйгээр бариулах нь “үндэслэлтэй боломж” гэж үзэх, эсвэл шинжлэх ухаан талаасаа тухайн бүс нутагт явуулсан үйлдвэрлэлд туршин нэвтрүүлэх үндэсний, хоёр эсвэл олон талт хамтын ажиллагаа, иргэний нийгэм мөн хувийн хэвшлийн хөтөлбөрүүдийн ажиллагааны үр дүнд мөнгөн усгүй технологи ашигласнаар уурхайчдын орлого буурахгүй гэдгийг нотлон харуулсан тохиолдолд мөн “үндэслэлтэй боломж” гэж үзэн мөнгөн ус хэрэглэхийг хориглоно.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд алтны хүдрийг бүхэлд нь мөнгөн усаар бариулахыг хориглоно. Мөнгөн усны нэгдэл үүсгэх үйл явцын өмнө мөнгөн усгүйгээр баяжуулах ажиллагаа хийгдэх ёстой.

- Үндсэн ордын олборлолтын хувьд хүдрийг бутлах, нунтаглах, дахин нунтаглах, баяжуулах, ялгах ажиллагааг мөнгөн ус ашиглалгүйгээр хийх ёстой. Зөвхөн дээр дурдсан боловсруулах ажиллагаа явагдсаны дараа баяжмалд мөнгөн ус ашиглахыг зөвшөөрнө. Ашигт малтмалыг хоёрдогч, шороон ордоос

боловсруулахдаа шлюзын хайрцаг, түмпэнд угаах болон бусад таталцлын аргаар салгах ажиллагаанд мөнгөн ус хэрэглэхийг зөвшөөрөхгүй, зөвхөн баяжмалаас алтыг ялгаж авахад хэрэглэхийг зөвшөөрнө.

- Мөнгөн усаар бариулсан нэгдлийг задлахдаа ууршуулах эсвэл мөнгөн ус ялгах бусад аргыг хэрэглэх ёстой. Харин Мөнгөн усаар бариулсан нэгдлийг задлахад азотын хүчил ашиглахыг хориглоно. Энд дурдсан азотын хүчил нь зөвхөн нэгдлийг задлахад хэрэглэгдэнэ.
- Мөнгөн усаар бариулсан нэгдлийг шатаах ажиллагааг гэр орон, галын өрөө, байшин дотор, хот суурин газар, амралт зугаалгын газар гэх мэт хамгаалалтгүй хүмүүс өртөж болзошгүй газарт явуулахгүй. Бариулсан нэгдлийг боловсруулахдаа уурхайчдыг хамгаалах, ялгарч байгаа ууршилтыг цэвэрлэх арга хэмжээ арга хэмжээ авсан тусгай зориулалтын газарт явуулах бөгөөд мөнгөн устай үйл ажиллагаанд ашигласан багаж, хэрэгсэлийг гэр ахуйн бусад ямар ч ажиллагаанд хэрэглэж болохгүй.
- Тэсрэх бодис, мөнгөн ус, цианид гэх мэт хортой, аюултай бодисыг оршин суугаа газар, орон гэртээ хадгалах ёсгүй бөгөөд аюулгүй хадгалалт, бараа материалын бүртгэл, устгалын хангалттай нөхцөл бүхий зохих ёсоор тэмдэглэгээжүүлсэн газарт хадгалах ёстой.
- Мөнгөн ус, цианид гэх мэт хортой, аюултай бодисуудын хэрэглээг 18-аас дээш насны сургалтанд хамрагдсан хүнд хариуцуулах бөгөөд жирэмсэн, хөхүүл эхчүүд, оюуны хомсдолтой хүн, ходоод гэдэс, шээсны зам, мэдрэл, амьсгалын системийн өвчтэй хүмүүст хариуцуулж болохгүй.
- Цианидийн уусмал, хаягдал шаарыг гадагшлуулахаас өмнө үелсэн цөөрөм эсвэл саванд хийж хорыг гаргах ёстой бөгөөд мөнгөн усаар бариулах ажиллагаа, цианидаар уусгалтын хаягдал шаар, уусмалыг усны эх үүсвэр эсвэл усны эх үүсвэрт хүрч болох газар асгаж болохгүй.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд цианидаар уусгах цехийг гэрчилгээжүүлэлтийн эхний жилээс хойш ажиллуулж буй тохиолдолд шат ахисан шаардлагуудын хүрээнд аюулгүй ажиллагаанд сургагдсан ажилтан хариуцаж ажиллана. Харин 3 дахь жилээс мөнгөн усаар бариулсан нэгдлийг шатаах ажиллагааг нууцлал, аюулгүй байдлын шаардлагыг хангасан, зохих тоног төхөөрөмж, сургагдсан ажилтан бүхий зориулалтын газар хийнэ. Хэрэв чөлөөлөгдсөн алтыг цэвэршүүлэхийн тулд азотын хүчил тогтмол⁸ ашигладаг тохиолдолд цэвэршүүлэх ажиллагааг шингэн болон хийн ялгаралтыг саармагжуулахад зориулсан тоног төхөөрөмж бүхий зориулалтын газар, энэ чиглэлээр сургагдсан ажилтнаар хийлгэх ёстой.

Мөнгөн усны хольц бүхий боловсруулаагүй хаягдал шааранд цианитаар уусгалт хийж болохгүй. Хэрэв мөнгөн усны хольцтой усаар уусгалт хийх тохиолдолд уусгалт хийхийн өмнө таталцлын аргаар урьдчилсан боловсруулалт хийж мөнгөн усыг ялгана.

2.5.2 Экосистемийн хамгаалалт

Экосистемийн хамгаалалтын хүрээнд байгаль орчинд ээлтэй технологи ашиглан орон нутгийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх явдал юм. Үүний тулд уурхайчид байгаль орчны менежментийн практикаа сайжруулахыг хөхиүлэн дэмжих, байгаль орчны хууль журмыг даган биелүүлэх, усны менежмент, газрын нөхөн сэргээлт хийх, аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хаягдал хүдэр, хог хаягдлын менежмент хийх, хүчлээр уусгах технологийг (ХУТ) багасгах, усны бохирдлоос урьдчилан сэргийлэх замаар энэ зорилгыг биелүүлнэ.

Шударга олборлолтын байгууллага нь Бичил уурхайгаас байгалийн тусгай хамгаалалттай газрууд, эмзэг экосистемд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахыг зорьдог бөгөөд үндэсний хууль тогтоомжоор уул уурхай эрхлэхийг хориглосон тусгай хамгаалалттай (бүхэлд нь эсвэл хэсэгчилсэн) газар байрлах ёсгүй. Шударга

⁸"Тогтмол ашигладаг" гэдэг нь дунджаар нэг сард 1 литрээс дээш баяжуулсан азотын хүчил хэрэглэх хэмжээнд хамаарна.

олборлолтын байгууллага нь тусгай хамгаалалттай газар явуулж буй уурхайн үйл ажиллагааг гэрчилгээжүүлэлтийн хүрээнээс хасдаг бөгөөд уг стандартын түр хассан газрын (ТХГ) тухай журмын⁹ дагуу хүсэлт ирүүлсэн тохиолдолд эмзэг экосистем бүхий газар уурхай эрхлэх явдлыг гэрчилгээжүүлэлтээс хасч болно.

Олборлолтын газар нь ийм газарт байрлаж байгаа тохиолдолд тухайн БУБ зөвхөн дараах тохиолдолд тухайн хоригоос чөлөөлөгдөх хүсэлт гаргаж болно:

- Тухайн уурхайн үйл ажиллагаа хууль ёсны бөгөөд хамгаалалттай газар нутгийн байгаль орчны хадгалалт хамгаалалт, удирдлагын зорилтод нийцсэн болохыг холбогдох эрх бүхий байгууллагаас мэдэгдэж БУБ-д зөвшөөрөл өгсөн байх;
- Шударга олборлолтын гэрчилгээ авах хүсэлт гаргаж буй БУБ байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах төлөвлөгөөтэй байх;
- БУБ-ын үйл ажиллагаа явуулсан түүх эерэг байх;

БУБ нь тэдний үйл ажиллагаа тухайн газар нутагт амьжиргааг дээшлүүлэх чухал шийдэл болж байгааг нотлон харуулж чаддаг байх.

Үйлдвэрлэлийн системд орох уул уурхайн бүх үйл ажиллагаа, боловсруулах үйлдвэр цехүүд байгаль орчны тухай үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөн, тэдгээрт заасан шаардлагын дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй байх ёстой.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд ил уурхай ажиллуулж байгаа тохиолдолд бэлийн налуу, давхаргын өндөр нь тухайн төрлийн хөрс, чулуулгын хувьд ерөнхийдөө аюулгүй байх ёстой. Мөн түлш шатахуун, тэдгээрийн савыг усны эх үүсвэр бүхий газар эсвэл усны эх үүсвэрт хүрч болзошгүй газар хаяж болохгүй. Тэдгээрийг эрүүл ахуй, байгаль орчинд эрсдэлгүйгээр боловсруулах эсвэл хаяж устгахыг ёстой.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд гэрчилгээжүүлэлтэнд орохоос өмнө БУБ нь аливаа технологийн өөрчлөлтийн байгаль

⁹ШО-ын стандартын хувилбар 2.0, 0.2.10 б дүгээр хэсэг

орчинд үзүүлэх нөлөөг үнэлж, боломжтой бол байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах төлөвлөгөө боловсруулах ёстой.

Үйлдвэрлэлийн системийн хүрээний оролцогч талууд ахисан түшины шаардлагуудын хувьд гэрчилгээжүүлэлтэнд хамрагдсанаас хойш 3 дахь жилээс дараах шаардлагуудыг хангаж ажиллана.

- Олборлолтын үйл ажиллагаа дууссаны дараа ил ба далд уурхайн нүхийг бөглөх буюу хааж экологийн нөхөн сэргэлт явагдах, аюул ослоос сэргийлэх боломжтой болгох.
- Уурхайн ажиллагаанд хүчлээр уусган хатаах арга хэрэглэж болзошгүй тохиолдолд хүчил үүсгэгч материалуудыг уснаас ялгаж авах үр дүнтэй арга хэрэглэх.
- Хаягдал шаар болон бохир усыг усны эх үүсвэр эсвэл усны эх үүсвэрт хүрч болзошгүй газар асгахгүй байж, менежментийг зохих ёор төлөвлөж туршлагатай мэргэжлийн хүнээр хийлгэх. Уурхайн хог хаягдлыг хаяж устгах ажиллагааг хог хаягдлын менежментийн сайн төлөвлөгөөний хүрээнд тэргүүн туршлага ашиглан шийдвэрлэх.
- Үйл ажиллагаа явуулсан газартаа тухайн экосистем, цаашид ашиглах зориулалтад тохирсон байр зүйн сэргээлт хийх замаар нөхөн сэргээх, орон нутгийн захиргааны газар төлөвлөлтийн тэргүүлэх чиглэлд нийцсэн байдлаар өвс ургамал тарьж ургуулах.

2.5.3 Экологийн алт, мөнгө, цагаан алт

Экологийн алт, мөнгө, цагаан алт болон дагалдах үнэт металл олборлолт нь ой модыг нөхөн сэргээх болон экологийн нөхөн сэргээлт хийх зэрэг байгаль орчны хатуу хяналт шаардлагын дагуу явагдсан тохиолдолд нэмэлт шагналыг олгохыг зөвшөөрдөг. Үйлдвэрлэлийн системд зөвхөн таталцалын аргаар, ямар нэг мөнгөн ус, цианид ашиглахгүйгээр боловсруулахыг хүлээн зөвшөөрдөг.

Экологийн шагнал олгох журам, гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага нь Шударга олборлолтын шагнал олгохтой төстэй. Мөн Экологийн шагнал нь мөнгөн ус, цианидгүй боловсруулалтын техник ашигласан, олборлолтын эрчимтэй бус үйл ажиллагаа явуулсны

улмаас алтны гарц буурсантай холбоотой эдийн засгийн алдагдлыг нөхөн төлж болно.

Экологийн алтны үйлдвэрлэлийн системийн хүрээнд гэрчилгээжүүлэлтэнд хамрагдахийн өмнө ашигт малтмалын боловсруулалтад мөнгөн ус, цианид ашиглахгүй, зөвхөн таталцлын аргаар боловсруулах арга хэрэглэдэг байх бөгөөд хаягдал шааранд ч ашиглах ёсгүй. Хэрэв ашигласан тохиолдолд цэвэр таталцалын аргаар боловсруулсан алтанд нь “экологийн” гэсэн гэрчилгээ олгохгүй, уг алтыг бүхэлд нь “Шударга олборлолтын” гэж баталгаажуулах боломжтой боловч “экологийн” гэж баталгаажуулсан гэрчилгээ олгох боломжгүй. БУБ нь орон нутгийн захиргаанаас батласан газар төлөвлөлтийн тэргүүлэх чиглэлийн дагуу ашиглаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлж, анхнаасаа экосистемийн унаган төрхийг нөхөн сэргээх ажиллагаа явуулах замаар уурхайн үйл ажиллагаанаас экологид учруулах хохирлыг аль болох багасгаж ажиллана.

2.6 Хөдөлмөрийн нөхцөл

Хөдөлмөрийн нөхцлийн хувьд шалгуурууд нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас (ОУХБ) дэлхий нийтийн зорилт болгон эхлүүлсэн зохистой ажлын тухай үзэл баримтлалд тулгуурласан. Зохистой ажлын тухай үзэл баримтлалыг ажиллах эрх, ажил эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн яриа хэлэлцээр гэсэн дөврөн үндсэн зорилтод нэгтгэн дүгнэж болно.

ХУУХ-ноос энэхүү үзэл баримтлалд тулгуурлан, бичил уурхайн ерөнхий онцлогт тохируулсан цуврал шалгуур үзүүлэлтийг ажил эрхлэлтийн төрөл бүрээр гаргасан байна.

Энэхүү СТАНДАРТ нь дараах зарчмын дагуу хөдөлмөрийн нөхцлөөр хангахыг шаардаж байна:

Хөдөлмөрийн шаардлага нь Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд хамаарах бүх уурхайчдад хамаарна. Үүнд бүх ажилчид, ажиллагсад, гишүүд буюу эзэд, жижиг үйлдвэрийн газар, үйлдвэрлэл эрхлэгчид, хувиараа ашигт малтмал олборлогч

иргэд (захиргаа, үйлдвэрлэлийн болон өрхийн боловсруулах цех, ашигт малтмал олборлолт) бүгд орно. Эрүүл ахуй, аюулгүй байдал, албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгах тухай босго шаардлагууд БУБ-ын олборлолтын газар нутагт бүхэлд нь үйлчилнэ. (БУБ-ын 1, 2-р түвшний үүрэг хариуцлагад)

БУБ-ын зүгээс олборлолтын талбай дээр ажиллах нөхцлөө аажмаар сайжруулж жигдрүүлэх, Шударга олборлолтын үр шимийг ажилчидтайгаа хуваалцах үүднээс Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах төлөвлөгөөтэй байна.

БУБ нь олборлолтын газар нутаг ажиллаж буй ажилчид, уурхайчид, хамтран оролцогч талуудтай болон ШОҮС-д оролцож буй талуудыг хамруулсан хөдөлмөрийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг хийж ажиллаж бөгөөд энэ нь цаашидын жил ирэх тутмын хөгжлийг хэмжих суурь зүүлэлт болгох юм.

Үнэлгээгээр дараах нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлно.

- Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл
- Нийгмийн хамгаалал
- Ажил эрхлэлтийн нөхцөл
- Хөдөлмөрлөх эрх чөлөө
- Хүүхдийн хөдөлмөрийн устгах шаардлага
- Ялгаварлан гадуурхалаас ангид байх эрх чөлөө
- Эвлэлдэн нэгдэх, хамтран тохиролцох эрх чөлөө

Мөн БУБ нь сайжруулах нэмэлт чиглэлүүдийг тодорхойлж болно.

БУБ-ын 1, 2-р түвшний хариуцлагын хүрээнд хөдөлмөрлөх нөхцлийн дараах шалгууруудыг хангаж ажиллана.

2.6.1 Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал

СТАНДАРТ нь ОУХБ-ын 155 дугаар конвенцийг (Хөдөлмөрийн эрүүлахуй, аюулгүй байдал) мөрдлөг болгох бөгөөд ажиллах орчинтой холбоотой, ажлаас үүдсэн, ажилтай холбоотой, шинээр бий болсон осол эндэгдэл, эрүүл мэндийн асуудлаас урьдчилан сэргийлэх, хэрэгжиж болохуйц үндэслэлтэй аргууд ашиглан тэдгээрийг аль

болох хамгийн бага түвшинд хүргэж бууруулахад чиглэгдэнэ. Уул уурхайн бүхий л ажиллагаанд баримтлах аюулгүй ажиллагааны наад захын шаардлагуудыг тогтоосон ОУХБ-ын 176 дугаар конвенцийг (Уурхайн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй) үе баримтлах бөгөөд БУБ-ын хамрах хүрээнд ажиллаж буй бүх уурхайчдад эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцлүүд үе шаттайгаар үйлчлэх ёстой. Эдгээр нөхцлийг ШОУС-ийн түвшинд дагаж мөрдөхөд БУБ хяналт тавиад зогсохгүй үүний үлгэр жишээ, бодлого, сургалтын үр дүнд тулгуурлан эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны практикийг уурхайн нийт газар нутгийн хэмжээнд дэмжин сурталчлаж ажиллана.

БУБ байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын хүрээнд дараах шаардлагуудыг биелүүлж ажиллана.

- Бүх уурхайчид хувийн хамгаалалтыг ашиглах
- БУБ-ын ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны үйл ажиллагаа явуулах хороотой байх
- Ажлын байр, машин тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангасан байх
- Ажилтай холбоотой бүх осол, нас баралт, өвчлөлийн бүртгэлийг хөтөлдөг байх.
- Бүх уурхайчид эрүүл мэнд, уурхайн аюулгүй байдлын эрсдэлийн талаар суурь сургалтад хамрагдуулсан байх.
- Анхны тусламжийн хөтөлбөр, журамтай байх
- Аврах ажиллагааны төлөвлөгөөтэй байх.
- БУБ жендэрийн ялгавартай хүчирхийллийг зохицуулах тодорхой бодлого, журамтай байх
- Ажлын байран дээрх эрсдэлийг тогтоох, хяналтын системтэй болох
- Уурхайчдад ажлын байран дээрх болон нийгэм дэх бэлгийн дарангуйллын тухай мэдлэг тогтмол олгох.
- Үйлдвэрлэлийн системийн хүрээнд бүх уурхайчин уурхайн эрүүл ахуй, аюулгүй байдал, түүний эрсдэл, аюулууд, онц байдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх, бэлтгэх, хариу үйлдэл хийх талаар мэдээлэл авах, сургалтанд хамрагдах боломжтой байх. Мөн бүх уурхайчин эрүүл мэндийн

тогтмол үзлэгийн хөтөлбөр, түүний дотор эмэгтэйчүүдийн эрүүл мэндтэй холбоотой үйлчилгээнд хамрагдах ёстой. Гэрчилгээжүүлэлтийн эхний жилд эрүүл мэндийн үзлэгийн бүртгэлийг хийсэн байх ёстой. Хуулиар заавал үзүүлэхээр шаардаагүй бол уурхайчид эрүүл мэндийн үзлэгт орохоос татгалзах эрхтэй.

- БУБ нь уурхайн үйл ажиллагаанаас болж тухайн нийгэмд бий болж буй осол эндэл, гарч буй гамшгийн үндсэн эрсдэл, эмзэг өртөмтгий байдлыг хүйсийн ялгавартайгаар задлан шинжилж дүгнэх чиглэлд орон нутгийн удирдлагууд ба холбогдох талуудтай хамтарч ажиллана. Тогтоогдсон үндсэн эрсдэл, эмзэг байдлуудыг шийдвэрлэх талаар үйл ажиллагааны төлөвлөгөөг ард иргэдийн хүрээнд гаргаж ажиллана.

2.6.2 Нийгмийн хамгаалал

Шаардлагын гол үзэл санаа бол нийгмийн хамгааллын сүлжээнд хамрагдсан албан ёсны нийгмийн даатгалын тогтолцоо байхгүй тохиолдолд эрэгтэй, эмэгтэй уурхайчдыг эрүүл мэндийн болон тэтгэврийн даатгалд хамрагдах боломжоор хангах явдал юм.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд нийгмийн хамгааллын систем байхгүй тохиолдолд осол гэмтэл, мэргэжлийн өвчин, гамшигт өртсөн уурхайчид гишүүдээс цуглуулсан эдийн засгийн дэмжлэгээр дамжуулан эв нэгдлийн хандив олгох ёстой. Уурхайн болон БУБ-ын нас барсан хувь зэмшигчдийн өв залгамжлагчид холбогдох эрх, үүргийг залгамжилж авна.

Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд орсон бүх уурхайчид эрүүл мэндийн, тэтгэврийн, мэргэжлийн эрсдэлийн даатгал бүхий нийгмийн даатгалд хамрагдан үр шимийг хүртэх ёстой бөгөөд энэ нь улсын нийгмийн даатгалд бичил уурхайчид хамрагддаг, зохих ёсоор ажилладаг улс оронд хамаарна. Хэрэв хуулиар нийгмийн даатгалд заавал хамрагдах үүрэгтэй бол зайлшгүй хамрагдана.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд бичил уурхайчин нас барсан тохиолдолд түүний элбэсэн эхнэр, нөхөр, үр хүүхдэд нөхөн төлбөр олгох нь гэрчилгээжүүлэлтийн 3 дахь жилээс мөрдөгдөнө. Энэ нь

зөвхөн үндэсний хуулинд заасны дагуу тэтгэврийн систем болон мэргэжлийн эрсдэлийн даатгалд хамрагдаагүй ажилчид, уурхайчдад хамаарна.

2.6.3 Ажил эрхлэлтийн нөхцөл

ОУХБ-ын 100 дугаар конвенцийг (Адил тэгш цалин хөлс) мөрдлөг болгоно.

Шударга олборлолтын байгууллага нь амьжиргааны олон янзын эх үүсвэртэй, бичил уурхайд бүтэн цагаар байнга ажилладаггүй хувиараа бизнес эрхлэгчдийг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү СТАНДАРТ нь бичил уурхайн ажлыг байнгын, тогтвортой, ажил олгогчид (тогтвортой ажиллах хүч) болон ажиллагсдад (нийгмийн хамгаалал бүхий тогтвортой ажлын байр) аль алинд нь ашигтай, илүү сонирхол татам болгох зорилготой.

Иймд ажилд авсан бүх ажилчид ажил эрхлэлтийн адил тэгш боломж эдлэх ёстой. Аль ч ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эсвэл бүс нутгийн дундаж цалин хөлсний тухай үндэсний хууль тогтоомж, гэрээнд заасан хэмжээний буюу түүнээс дээш цалин хөлс олгох болно. Түүнчлэн уг СТАНДАРТ нь ашиг хуваах гэрээ болон мөнгөн бус хангамжууд цагаа олсон, ил тод, шударга байлгахыг эрмэлзэнэ.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд дараах шаардлагуудыг хангаж ажиллана.

- Хөлсний ажилтан нь тухайн улсын хууль журмын дагуу ажил олгогчтой гэрээ хийж ажиллана.
- Холбогдох хангамж материалаар хангуулна.
- Хөлсний ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, цалин хөлс нь салбарын дундаж цалин эсвэл ижил төстэй мэргэжлийн албан ёсны хамгийн доод цалингийн аль өндөртэй ижил буюу түүнээс илүү байх ёстой. Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн хүрээнд орсон аливаа ажил олгогч бүх ажил үүргийнхээ цалинг тодорхой заасан байна. Ашиг хуваах гэрээний дагуу (ийм гэрээтэй бол) олсон дундаж орлого нь тогтмол цалин авснаар олох орлогоос бага байх ёсгүй.

Төлбөрийг харилцан тохиролцож, зохих ёсоор баримтжуулсны дагуу хууль ёсны төлбөрийн хэрэгсэл эсвэл “мөнгөн бус” хэлбэрээр (хүдэр, алт) тогтмол, хугацаанд нь төлж байх ёстой. Ваучер, купон, амлалтыг бичиг хэлбэрээр төлөхийг хориглоно.

- Хөлсний ажилчдын авч болох өвчний чөлөө, ээлжийн амралт, жирэмсэний амралт, нийгмийн хамгааллын заалтууд, мөнгөн бус хангамж нь үндэсний хууль тогтоомжид заасан, салбарын Хамтын гэрээтэй бол түүнд заасан, эсвэл ажилчдын байгууллага ба ажил олгогчын хооронд байгуулсан гэрээнд заасан хэмжээний аль ихээс багагүй байх ёстой.
- Ажлын цаг болон илүү цагийн хэмжээ холбогдох хууль тогтоомж, салбарын стандартуудад нийцсэн байна, Гэвч хөлсний ажилчид ажлын ердийн цагийн хувьд долоо хоногт 48 цагаас илүү ажиллах ёсгүй.
- Ажил олгогч ба ажилтны хооронд харилцан тохирч тогтоосон хэвийн бус ажлын цагтай байж болно. Хэвийн бус ажлын цаг нь амралтын цагтай, үндэсний хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Хөлсний ажилчдын хувьд илүү цагийн ажил нь сайн дурын байх бөгөөд онцгой нөхцөл байдал биш бол долоо хоногт 12 цагаас хэтрэх ёсгүй.
- Хууль тогтоомжоор зөвшөөрсөн, уурхайчдын хувьд үндэслэлтэй, тэгш шударга гэж үзсэн тохиолдолд ажилчдын байгууллага (нэг ажилчин биш) ба ажил олгогчын хооронд хоёр талын ашиг сонирхолд нийцсэн гэж үзсэн бусад стандарт ажлын цагийг харилцан тохирч гэрээ байгуулж болно.
- Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд ажилчид долоо хоногт дорхаяж нэг удаа 24 цагийн турш амрах ёстой. Боломжит онцгой нөхцөл нь уул уурхайн салбарын хууль тогтоомжид нийцсэн байна. Онцгой нөхцөлийг тогтмол хэрэглэж болохгүй.
- Хууль тогтоомжоор зөвшөөрсөн, уурхайчдын хувьд үндэслэлтэй, тэгш шударга гэж үзсэн тохиолдолд ажилчдын байгууллага (нэг ажилчин биш) ба ажил олгогчын хооронд хоёр талын ашиг сонирхолд нийцсэн гэж үзсэн бусад стандарт ажлын цагийг харилцан тохирч гэрээ байгуулж болно.

- Хөлсний ажилчдын хувьд ээлжийн амралт нь өвчний болон ердийн чөлөөг оруулахгүйгээр жилд хоёр долоо хоногоос багагүй байна.
- Хөлсний ажилчид бүгд хуулиар заавал даган биелүүлэх үүрэг бүхий гэрээтэй байна.
- Хэрэв БУБ буюу ажил олгогч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд ажилчдыг хөлслөн ажиллуулахаар гуравдагч талтай гэрээ байгуулсан бол уг талыг БУБ-ын хүрээнд хамруулж, Шударга олборлолтын бүхий л шаардлагыг мөрдүүлэх ёстой.
- Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд 3-аас дээш жил ажиллаж байгаа байнгын хувиараа ашигт малтмал олборлогч иргэд тухайн газрын эзэнтэй ашиг хуваах шударга, ил тод гэрээтэй байх ёстой.
- Ажил гүйцэтгэлийн хэмжээ ижил тохиолдолд ялгавартай цалин хөлс өгч болохгүй.
- Хэрэв ажилчдын байр сууцаар хангаж байгаа тохиолдолд тухайн байрны нөхцөл, дэд бүтэц нь эрүү ахуй, эрүүл мэндийн шаардлага хангасан, тохь тух, хувийн нууц, аюулгүй байдлыг хангахуйц байна.
- Хэрэв ямар нэг хязгаарлалтууд байгаа бол тэдгээр нь ялгаварлан гадуурхсан шинжтэй бус, хөдөлмөрийн эрх чөлөөний зарчмуудад нийцсэн (албадан хөдөлмөр байхгүй) гэдгийг тухайн БУБ нотлон харуулах шаардлагатай.

2.6.4 Хөдөлмөрлөх эрх чөлөө

Шударга олборлолтын стандартын хүрээнд ОУХБ-ын 29 дүгээр конвенцийг (Албадан хөдөлмөрийн тухай) мөрддөг бөгөөд ажилчид ямар нэг заналхийлэл, шийтгэлгүйгээр сайн дураар, чөлөөтэй хөдөлмөр эрхлэх эрхтэй ба хэзээ ч, ямар нэг шийтгэлгүйгээр ажил эрхлэлтээ зогсоох эрхтэй эрх чөлөөний заримын шаардлагуудыг дагна. Мөн уурхайчин, байгууллага эсвэл зуучлагч талын хоорондын өрийн схем, төлбөл зохих төлбөрийг өгөхгүй саатуулах, бичиг баримт, бусад хувийн эд зүйлсийг барьцаалах, заналхийллийн дор ажиллуулах, хүний шилжилт хөдөлгөөний эрх чөлөөг хязгаарлах гэх мэт хэлбэртэй албадан болон боолын хөдөлмөр байх ёсгүй. Албадан

хөдөлмөр, түүний дотор боолчлолын, сайн дурын бус, шоронгийн хөдөлмөр, байх ёсгүй. Эхнэр, нөхөр нь өөр хаа нэгтээ ажиллах эрхтэй бөгөөд аливаа ажилчны ажил эрхлэлтэд түүний эхнэр, нөхрийн ажил эрхлэлтээс хамаарсан нөхцөл болзол тавих ёсгүй.

2.6.5 Хүүхэд хамгаалал ба хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсоох үүрэг

Шударга олборлолт нь Хөдөлмөрийн доод насны тухай ОУХБ-ын 138 дугаар конвенци, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцийг тус тус мөрдлөг болгодог. СТАНДАРТ-аар Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглож, БУБ-ууд тэдгээрийг таслан зогсоох шууд, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллахыг дэмждэг. Иймд БУБ-ууд хөдөлмөр эрхэлж буй хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг хүүхэд асрах газраар хангах явдлыг шат ахисан түвшний шаардлага болгон тавьж, БУБ-ын олборлолтын талбайд эмэгтэйчүүд ажилладаг тохиолдолд Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөндөө оруулах хэрэгтэй. БУБ-ын олборлолтын талбайд 7-14 насны хүүхэд ажиллах ёсгүй бөгөөд боломжтой бол тэд сургуульд суралцдаг байх шаардлагатай.

Хэрэв өрх толгойлсон эсвэл гэр бүл, асран хамгаалагчдын хүрээнээс гадуур амьдардаг хүүхдүүд БУБ-ын олборлолтын талбайд хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа нь тогтоогдвол тэдний сайн сайхан, аюулгүй байдлыг хангах үүднээс НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн үндсэн зарчмуудыг мөрдлөг болгох ёстой.

Хэрэв эдгээр хүүхдүүд (15-18) хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хийж буй тогтоогдвол тэднийг нэн даруй татан авч, орлого олох өөр аюулгүй боломжоор хангах ёстой бөгөөд 15-аас доош (үндэсний хууль тогтоомжид заасны дагуу) насны хүүхдүүдийг чөлөөт цагийн сургуульд хамруулна.

БУБ хүүхэд хамгааллын сургалтад хамрагдаж, системийн хэмжээний Хүүхэд хамгааллын бодлого, журамтай болж, хүүхдийн хөдөлмөрт хяналт тавьж, засч залруулах ажилд ард иргэдийг татан оролцуулдаг байна.

Энэхүү хэсгийн шаардлагууд нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн хувьд Босго шаардлага (БУБ-ын 1 дүгээр шатны үүрэг хариуцлага), БУБ-ын уурхайн олборлолтын нийт газар нутгийн хувьд Шат ахисан шаардлага (БУБ-ын 2 дугаар шатны үүрэг хариуцлага), уурхай эрхлэгч ард иргэдийн хувьд Шат ахисан шаардлага (БУБ-ын 3 дугаар шатны үүрэг хариуцлага) болж үйлчилнэ.

18-аас доош насны хүүхэд өөрийн онцлог, тухайн ажил хийгдэх орчин нөхцлийн хувьд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор хохирол учруулахуйц ямар нэг төрлийн аюултай хөдөлмөр эрхлэх **ажилд орох буюу гэрээ байгуулах** ёсгүй. Энэхүү СТАНДАРТ нь Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахын тулд хориглох, нэн даруй авах арга хэмжээний тухай ОУХБ-ын 1999 оны конвенцийг баримталж уг ойлголтыг “өөрийн онцлог, тухайн ажил хийгдэх орчин нөхцлийн хувьд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор хохирол учруулахуйц ажил”, “энэ бол хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт муу, ажлын зохион байгуулалт муутайгаас болж хүүхэд амь насаа алдах, бэртэж гэмтэх, өвчин тусч болзошгүй аюултай, эрүүл бус нөхцөл” гэж тодорхойлдог.

БУБ-ын хүрээнд **Гэр бүлийн хөдөлмөр**-т оролцож буй 18-аас доош насны хүүхэд газрын гүн, усан доорх ажил, хүнд ачаа өргөх, хорт бодис ашиглах, шөнийн ээлжинд ажиллах, уртасгасан ээлжээр ажиллах, хичээлийн хуваариас өмнөх ээлжинд ажиллах ажлуудыг хийх ёсгүй бөгөөд энэхүү шаардлага нь тухайн БУБ-ын хэмжээнд 3 жилийн дараа үйлчлэхээр байна.

Хүүхэд өрх толгойлох явдал системтэйгээр бий болж, том хүүхдүүдийнх нь уурхайгаас олсон орлого өрхийн орлогод чухал шийдвэрлэх ач холбогдолтой байгаа нөхцөлд БУБ-аас эдгээр хүүхдийн сайн сайхан, аюулгүй байдлыг хангахын тулд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн үндсэн зарчмуудыг мөрдлөг болгох бөгөөд Гэрчилгээ олгогч байгууллагас 3 жилийн хугацаатай онцгой нөхцөл олгосны дагуу (1) боловсрол, хөгжил, мэргэжил, эдийн засаг, нийгмийн боломжууд олгох (2) ажил эрхэлж буй хүүхдийг ажлын

байрны аюулаас хамгаалахын тулд залуучуудын ажил эрхлэлтийн хөтөлбөртэй болох ёстой.

3 жилийн дараа уг залуучуудын ажил эрхлэлтийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагыг дахин үнэлж, үргэлжлүүлэхээр болсон тохиолдолд БУБ-ын хэмжээнд байгаа нийт өрх толгойлсон хүүхдийг уг хөтөлбөрт хамруулах ёстой.

БУБ эдгээр залуусыг ажиллуулахын өмнө гэрчилгээ олгогч байгууллагаас онцлогоо нөхцөл олгохыг хүсэх бөгөөд үүнд а) орон нутгийн ХУУХ-ны дэмжлэг үзүүлэх баг эсвэл тухайн чиглэлээр ажиллаж буй холбогдох ТББ-ын, б) орон нутгийн буюу тосгоны захиргааны санал зөвлөмжийг хавсаргасан байна.

Хүүхдийн хөдөлмөр ихтэй газруудад ажиллаж буй БУБ нь орчин тойрны нутгийн ард иргэдийн дунд хүүхэд хамгаалал, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үйл ажиллагаа явуулах талаар Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөндөө тусгаж, хүүхэд хамгааллын сургалт явуулах, Хүүхэд хамгааллын бодлого, журамтай болох, олон нийтэд түшиглэн хүүхдийн хөдөлмөрт хяналт тавьж, засч залруулах ажиллагаанд орон нутгийн захиргаа, бусад бүлгийг татан оролцуулж ажиллана. Залуусыг аль болох тэдний эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөлгүй, сурч боловсроход саадгүй зохистой ажил эрхлэлтээр хангаж, уурхайн олборлолтын талбайдаа ажиллаж буй өсвөр насныхныг техник мэргэжлийн сургалт, түүний дотор хариуцлагатай уул уурхайн ажиллагаанд хамруулах арга хэмжээг авч ажиллах ёстой.

2.6.6 Үл ялгаварлан гадуурхагдах эрх чөлөө

Шударга олборлолт нь хүнийг ямар нэг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, шашин, улс төрийн үзэл бодол, үндэсний зэрэг зиндаа, нийгмийн гарал зэрэг ажил эрхлэлт, ажил мэргэжилд адил тэгш хандах боломж, хандлагыг өөрчлөхүйц зүйлсээр ялгаварлах, хасч гадуурхах эсвэл илүүд үзэхийг хориглосон ажилчдыг ялгаварлан гадуурхахын эсрэг ОУХБ-ын 100 дугаар конвенци (Адил тэгш цалин хөлс) болон 111 дүгээр конвенцийг (Ялгаварлан гадуурхалт – Ажил эрхлэлт ба ажил мэргэжил) мөрдлөг болгодог. Энэхүү шаардлагын

зорилго бол өөрийн биеийн, соёлын, нийгэм, эдийн засгийн онцлогоос болж эмзэг байдалд орсон хүмүүс, ялангуяа эмэгтэй уурхайчид, хөгжлийн бэхршээлтэй, өвчтэй иргэд, ДОХ-ын халдварын улмаас өнчрөгсөд, шилжиж ирсэн ажилчид, зөрчил мөргөлдөөнөөс дүрвэгсэд, амьдралаа шинээр эхлэхийг хүсч буй цэргийн хүмүүсийг хамгаалах явдал юм.

БУБ нь үйл ажиллагааны хүрээндээ дээр дурьдсан ялгаварлан гадуурхах үзэл гаргахгүй байх шаардлагатай бөгөөд уурхайчид аливаа бие махбодийн шийтгэл, оюуны эсвэл биеийн хүч хэрэглэх, дохио зангаа, үг хэл, биед хүрэх зэрэг бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн зорилгоор ашиглах зан байдалд оролцох эсвэл хэл амаар доромжлох явдалд оролцох, дэмжих эсвэл хүлцэх ёсгүй.

БУБ болон түүний уурхайчид өөрийн олборлолтын газар ажиллаж байгаа нийт жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд (хувиараа ашигт малтмал олборлогч эмэгтэйчүүд, ашигт малтмал сонгон олборлогч эмэгтэйчүүд, хөлсний эмэгтэй уурхайчид гэх мэт) дэмжлэг үзүүлж улмаар тэднийг хөнгөн, аюул багатай ажилд шилжүүлэх, БУБ-ын эмэгтэй уурхайчдыг эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхэд асрах, хөхүүлэх газраар хангах, тэдэнд нийгмийн хамгааллын тэтгэмжүүд олгох асуудлаар олон нутгийн захиргаатай хамтран ажиллах талаар бүхий л боломжит хүчин чармайлтыг гаргана.

2.6.7 Эвлэлдэн нэгдэх, хамтран тохиролцох эрх чөлөө

СТАНДАРТ нь үйлдвэрчний эвлэл болон хамтын тохиролцооны эрх чөлөөний тухай ОУХБ-ын 87 дугаар конвенци (Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба зохион байгуулагдах эрхийн хамгаалалт) ба 98 дугаар конвенци (Зохион байгуулагдах ба хамтран тохиролцох эрх), мөн үйлдвэрчний эрх байгуулах эрхийн тухай ОУХБ-ын C454 дугаар конвенцийг мөрдлөг болгодог. Ажилчид ба ажиллагсад нь үйлдвэрчний эвлэл зохион байгуулалттайгаар байгуулах, тэдний сонгуульд оролцох, холбогдох дүрэм журам боловсруулах, төлөөлөгчиддөө сонгох, хөтөлбөрөө томъёолох эрхтэй байх ёстой. Ажилчид нь тэдний ажил эрхлэлттэй холбоотойгоор үйлдвэрчний эвлэлийн эрх чөлөөг бууруулахад чиглэсэн ямар нэг ялгаварлан гадуурхах үйлдлээс хангалттай хамгаалагдах ёстой.

Энэхүү хэсгийн зорилго нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн хүрээн дэх хөлсний ажилчдын хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, ажилчдад зохион байгуулалтад орох баталгаагаар хангах, ажил олгогч буюу эзэд болон БУБ доторх олборлогчид, ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хооронд нийгмийн яриа хэлэлцээ өрнүүлэхэд чиглэнэ. Энд хамаарах БУБ ба ажил олгогчдын аль нь ч ажилчдаа эвлэлжүүлэх үүрэггүй боловч нийгмийн яриа хэлэлцээр өрнөх боломжоор хангах ёстой.

БУБ-ын механикжуулалтын түвшин нэмэгдэхийн хэрээр бичил уурхайн салбарт хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс илүү хөлсний ажилчид ажиллах нь нэмэгдэх хандлагатай байна. Бичил уурхайн нийтлэг үйл ажиллагаа нь өрхийн үйлдвэрлэлийн нэгжүүд, хувиараа ашигт малтмал олборлогчид, бичил цех ба жижиг үйлдвэрийн газрууд, хөлсний ажилчид, цалинтай ажилчид зэргийг хослуулсан байж болно.

Үйлдвэрлэлийн системийн хүрээнд бүх ажил олгогчид нийт ажилчдынхаа зохион байгуулалтад орох, өөрсдийн сонголтоор ажилчдын байгууллагад нэгдэх, улмаар хөдөлмөрийн нөхцлөө хамтран тохиролцох эрхийг бичгээр, бодит байдал дээр хүлээн зөвшөөрөх мөн үйлдвэрчний эвлэл байгуулагчдыг нийт ажилчидтай уулзах, ажилчиддаа хурал цуглаанд оролцох, удирдлагын оролцоогүйгээр өөрсдийгөө зохион байгуулах боломж олгох бөгөөд ингэсний төлөө ажилчид ялгаварлан гадуурхагдахгүй байх, эсвэл ямар нэг хохирол амсахгүй байх нөхцлийг бүх ажил олгогч бүрдүүлж баталгаажуулна. Ажил олгогчын санхүүжүүлсэн сургалт, сайжруулалтын үйл ажиллагаа нь ямар ч тохиолдолд ажилтнуудын байгууллагыг хянах буюу ажил олгогчын хяналтад оруулахад зориулагдсан, тийм зорилго агуулсан үйлдэл хийхийг хориглоно.

БУБ-ын олборлолтын талбайд ажиллаж буй ажилчид, ажил олгогчдын дунд сургалт явуулах замаар ажилчдын нийгмийн яриа хэлэлцээр, төлөөлөл, зохион байгуулалт, оролцооны асуудлыг сайжруулж болно. БУБ-ын удирдлага энэ үйл ажиллагаанд зориулж хангалттай хөрөнгө хүч гаргах ёстой. Ажил олгогчид ажил

эрхлэгчдийн сонгуулийн үйл ажиллагаанд ямар нэг байдлаар нөлөөлөхийг цээрлэнэ.

2.7 Шударга олборлолтын шагналын удирдлага ба хөгжлийн төлөвлөгөө

Шударга олборлолтын шагнал ба Экологийн шударга олборлолтын шагнал нь БУБ-ын Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системээс гаралтай гэрчилгээ бүхий (тоо хэмжээ, гарал үүсэлд нь БУБ-ын Дотоод хяналтын системээр дамжуулан хяналт тавьсан) бүтээгдэхүүний үнэ дээр худалдан авагчийн зүгээс нэмж төлж буй мөнгийг илэрхийлнэ.

Шударга олборлолтын шагнал нь БУБ-ын хөгжлийг дэмжих нэг хэрэгсэл бөгөөд Бичил уурхайчдын хамтын нийгэмлэгээс БУБ-ын Шагналын хорооны Хөгжлийн төлөвлөгөөнд заасан хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. БУБ-ын хувьд энэ нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд орсон уурхайчид, БУБ-ын нийт гишүүд, мөн тэднээр дамжуулан тэдний гэр бүл, ажилчид, орчин тойрны нутгийн ард иргэдийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжилд оруулж буй урт хугацааны хөрөнгө оруулалт гэсэн үг юм.

БУБ-ын **Шагналын хороо** нь БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд оролцож байгаа нийгмийн бүх бүлгүүд, түүний дотор эмэгтэй уурхайчдыг төлөөлдөг бөгөөд орон нутгийн нийгмийн бусад бүлгүүдийн төлөөллийг урьж оролцуулж болно. Шагналын хороо нь Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах замаар Шударга олборлолтын шагналыг зарцуулах тэргүүлэх чиглэлүүдийг тогтоодог.

Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөг Шагналын хороогоор ардчилсан байдлаар хэлэлцэн батлаад БУБ-ын хурлаар хэлэлцүүлэхээр оруулдаг.

БУБ энэхүү Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөг хэлэлцэн батлаад **Шударга олборлолтын шагналын**

хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болгон задлаж хэрэгжүүлэх хууль ёсны үүрэг хүлээдэг.

БУБ нь Шударга олборлолтын шагналыг түүний үр шимийг хүртэгчдэд ил тод байдлаар захиран зарцуулах эрмэлзэл, чадавхитай байна. БУБ энэхүү Шударга олборлолтын шагналын ашиглалт, зарцуулалтын талаарх ард иргэдэд идэвхтэй мэдээллэнэ.

Уг Шагналын хөрөнгө оруулалтын талаарх шийдвэрийг ийнхүү танилцуулах зорилго нь БУБ-ын 1, 2, 3 дугаар түвшний үүрэг хариуцлагатай шууд холбоотой бөгөөд хэрэгцээ шаардлагын үнэлгээг дагалдуулах ёстой.

Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөө бол стратегийн төлөвлөгөөний хэрэгсэл бол, Шударга олборлолтын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь уг хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгсэл юм. Энэ хоёр төлөвлөгөө хоорондоо нягт уялдаатай байна.

БУБ Шагналын хорооныхоо эхний бүтэц бүрэлдэхүүн, БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн хүрээнд буй нийгмийн бүх бүлгийн тэгш төлөөлөл, мөн шаардлагатай бол орон нутгийн захиргаа, нийгмийн бусад бүлгийн төлөөллийг харгалзан ямар нэг ялгаварлан гадуурхалтгүйгээр, ардчилсан шийдвэр гаргах үйл явцыг тодорхойлсон дотоод дүрмийг нийтэд танилцуулж, мэдээлж байх ёстой. БУБ нь Шагналын хороондоо эмэгтэйчүүдийн тэгш төлөөлөл оруулахыг эрмэлзэх ёстой.

Шагналын хорооны дотоод дүрмийг БУБ өөрийн чуулганыг зохион байгуулж Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан бүх уурхайчид, БУБ-ын удирдлага, шаардлагатай бол БУБ-ын олборлолтын газар нутаг дахь эмзэг бүлгийн төлөөлөгчид, орон нутгийн эрх барих байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан хэлэлцэн батлах ёстой. БУБ нь Шударга олборлолтын хорооны нэгдсэн чуулганы тэмдэглэлийг хөтөлж, шийдвэрийн албан ёсны бичлэгийг баталгаажуулах шаардлагатай. Шагналын хороо нь гэрчилгээ авснаас хойш нэг жилийн дотор БУБ-тай хамтран

Шударга олборлолтын шагналын орлого нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн систем, БУБ, нутгийн ард иргэдийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжихэд хэрхэн туслаж болох талаар “хэрэгцээний үнэлгээ” хийж, үнэлгээнд тулгуурлан Шударга олборлолтын шагналыг ашиглах тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлж, Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөгөө БУБ-д өгч батлуулна. Мөн Шударга олборлолтын шагналыг ил тод удирдахын тулд Шударга олборлолтын шагналын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зориулсан нягтлан бодох бүртгэлийн системтэй байх ёстой.

БУБ нь гэрчилгээ авснаас хойш нэг жилийн дотор Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөнд шат ахисан шаардлага бүхий Хийхээр төлөвлөсөн зүйлс, үндэслэл, хугацаа, хариуцаж ажиллах эзэн, шаардлагатай төсөв, зардал зэрэг зүйлсийг оруулсан байна.

Мөн БУБ нь тухайн хугацаанд дараах зүйсийг хийж ажиллана.

- Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөө нь хэрэгцээний үнэлгээнд нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх,
- Шаардлагатай бол Шагналын хороотой хэлэлцэн тохиролцсон зөвшилцөлд үндэслэл бүхий өөрчлөлтүүд хийх,
- Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөг батлах,
- Шударга олборлолтын шагналын хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх замаар Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээх ёстой.

БУБ нь Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөө, Шударга олборлолтын шагналын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг баримтжуулж жил бүр Шагналын хороонд тайлагнахын зэрэгцээ гол оролцогч талууд (уурхайчид, ХУУХ ба орон нутгийн захиргаа) болон олон нийтэд мэдээлж байна.

БУБ тайландаа дараах асуултад хариулна:

- Үйл ажиллагаа хийгдсэн үү, тийм, үгүй? Хэрэв үгүй бол, яагаад?
- Хэзээ?
- Ямар зардлаар?

Зорилго биелсэн үү, эсвэл нэмэлт арга хэмжээ шаардлагатай юу?

2.8 Худалдааны харилцаа

СТАНДАРТ-ын худалдааны харилцааг зохицуулах үүднээс дараах дүрмийг тогтоов:

- Худалдааны харилцаа ба гэрээ
- БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн систем ба тухайн металлийг худалдан авагч буюу шагнал олгогчийн хооронд металл худалддаг буюу шилжүүлдэг операторуудад зориулсан гарал үүслийн хяналтын дүрэм,
- Шударга олборлолтын үнийн болон шагналын доод хэмжээ,
- Завсрын хагас боловсруулсан бүтээгдэхүүн, түүний дотор баяжуулалт, цэвэршүүлэлт, холимог (хайлш хийх) хэлбэрийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, худалдаа
- Урьдчилгаа төлбөр

Шударга олборлолтын үндсэн стандарт нь тухайн металл БУБ-ын гараас гарах хүртэлх үйлдвэрлэл, боловсруулалтын үеийг хамардаг.

Анхны эрх бүхий худалдан авагчаас цааш алтыг нэгэнт цэвэр алт болгон цэвэршүүлсний дараа Шударга олборлолтын системээс төрөл бүрийн зах зээлд зориулсан биет нийлүүлэлтийн загварыг санал болгодог.

Тухайлбал,

- **“Шударга олборлолтын нэгтгэл”** буюу **Fairmined Incorporated** гэсэн загвар нь төрөл бүрийн бизнесийн загварт уян хатан тохирч хэрэглэгддэг
- **“Шударга олборлолт тэмдэг”** буюу **Fairmined Labeled** загвар нь гарал үүслийн биет хяналтыг Шударга олборлолтоос

тодорхойлсон дүрмийн дагуу эцсийн хэрэглэгч хүртэл үргэлжлүүлдэг.

Энэ хоёр загварын нийтлэг онцлог бол Шударга олборлолтын гэрчилгээний схемээс стандартад бүрэн нийцсэн, ёс зүйн дээд зэргийн чанартай, гарал үүсэл нь тодорхой, гэрчилгээжүүлсэн Шударга олборлолтын алт нийлүүлж, хариуцлагатай бичил уурхайчид, тэдний хамтын нийгэмлэгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оршино.

Түүнээс гадна Шударга олборлолтын систем нь түүний биет нийлүүлэлтийн сувагт бүтээгдэхүүнээ борлуулах боломжгүй буюу борлуулах хүсэлгүй эсвэл Шударга олборлолтын алтыг өөрсдийн нийлүүлэлтийн сувагт биетээр оруулах сонирхолгүй боловч хариуцлагатай бичил уурхайчид, тэдний хамтын нийгэмлэгийн хөгжилд хувь нэмрээ оруулах хүсэлтэй БУБ-ууд эсвэл зах зээлүүдэд **“Шударга олборлолтын гэрчилгээ”**-ний загварыг санал болгодог. Шударга олборлолтын гэрчилгээ нь тухайн БУБ-аас гарал үүслийн биет хяналтын дор хууль ёсны худалдан авагчид борлуулсан Шударга олборлолтын гэрчилгээ бүхий алтыг “захиалж авах” схем юм.

2.8.1 Шударга олборлолтын биет нийлүүлэлтийн загварын хүрээнд дагах Стандартын үзүүлэлтүүд

Гэрчилгээтэй үйлдвэрлэгчээс худалдан авах: Нэгэнт гэрчилгээ авч баталгаажсан тохиолдолд Шударга олборлолтын шагналын захиран зарцуулалт, удирдлага, хариуцлагатай байдлын үүрэг хүлээж, гэрчилгээгээ хадгалахын тулд байнгын сайжруулалт хийж байх, БУБ өөрийн Дотоод хяналтын системээр (ДХС) дамжуулан зөвхөн БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системээр дамжин үйлдвэрлэгдсэн алтыг Шударга олборлолтын алт хэмээн борлуулах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Бүх Шударга олборлолтын алтыг гэрчилгээтэй БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системээр үйлдвэрлэсэн байх ёстой.

БУБ буюу түүний Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид худалдан авагч нарт гэрчилгээ бүхий алт борлуулж болно.

- Худалдан авагчид Шударга олборолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан бичил уурхайчидтай хийсэн бүх гүйлгээний тайлангаа БУБ-д ирүүлэх ёстой.
- Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдан гэрчилгээтэй алт хувиараа борлуулж буй бичил уурхайчид борлуулалтын бүх гүйлгээнийхээ тайланг БУБ-д гаргаж өгөх ёстой.

БУБ өөрийн Дотоод хяналтын системээр (ДХС) дамжуулан гэрчилгээтэй алтны бүх гүйлгээг нэгтгэн дүгнэх ёстой.

Худалдан авагч нь албан ёсны төрийн байгууллага бөгөөд ялангуяа уг байгууллага алтны арилжаа хийх хууль ёсны эрхтэй буюу монополь эрхтэй бол ХУУХ-ноос үндэсний хууль эрх зүйн хүрээнд үнэлэлт өгсний үндсэн дээр тухайн улсын онцлогтой СТАНДАРТ шаардлагуудыг гаргаж нийтэлнэ.

Бүх операторууд тухайн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу ажилладаг хуулийн этгээд байж, ХУУХ-ны тавьсан гэрээний нөхцлийн дагуу эрх авсан байх ёстой бөгөөд энэхүү СТАНДАРТ-ыг дагаж мөрдөж байгаа эсэхийг нь үнэлэхийн тулд аудит хийлгэнэ.

Үнэ тогтоолт: Шудрага олборлолтын доод үнийг (ШОДҮ) тогтоохдоо алт (Au), мөнгөний (Ag) хувьд Лондоны алтны биржийн холбооны (ЛАБХ) тогтоосон үнэ, цагаан алтны (Pt.) хувьд Лондоны цагаан алт, палладины биржийн (ЛЦАПБ) үнэд тулгуурладаг. Цаашилбал, маш их өрсөлдөөнтэй, эрэлтэд чиглэсэн алтны зах зээлийн хувьд Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан БУБ-ууд ба уурхайчдад Шударга олборлолтоос санал болгож буй үнэ нь ердийн зах зээлийн үнээс өндөр байгаа тохиолдолд зөвхөн Шударга олборлолтын худалдан авагчдад алтаа борлуулах болно. Энэ нь бас тухайн БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн дотоод нийлүүлэлтийн сувагт үйлчилнэ: БУБ нь дотоодын алтны зах зээл дээр санал болгож үнээс өндөр үнэ санал болгож байвал хувиараа ашигт малтмал олборлогчид алтаа зөвхөн БУБ-аар дамжуулж зарах болно.

Шударга олборлолтын шагнал: Шударга олборлолтын алт нь энэхүү хариуцлагатай уул уурхайн практикийг дагаж мөрдсөний “шагнал” болоод зогсохгүй хөгжлийг бий болгоход шаардлагатай хөрөнгийг БУБ-д олж өгөх хэрэгсэл болдог. Экологийн алтны үйлдвэрлэл нь БУБ-аас сайн дурын нэмэлт хүчин чармайлт шаарддаг учраас энэхүү хүчин чармайлтыг Экологийн нэмэлт шагналаар дамжуулан урамшуулдаг.

Эрх бүхий анхны худалдан авагч, БУБ буюу Үйлдвэрлэлийн системийн хүрээнд үнийг алт, мөнгөний хувьд ЛАБХ-ны үнэ, цагаан алтны хувьд ЛЦАПБ-ийн үнэд тулгуурлан тогтоох бөгөөд цэвэр агуулгатай металлийг экспортын цэгт FOB нөхцлөөр хүргэх ЛАБХ эсвэл ЛЦАПБ-ийн үнийн 95%-иас их (эсвэл ядаж тэнцүү) байх ёстой. Үнийн төлбөр тооцоог тухайн алтыг худалдан авагчид зарж байгаа БУБ-д эсвэл Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчдад бөөнөөр шилжүүлнэ.

Анхны урьдчилгаа төлбөрийг (сорьц тогтоохоос өмнөх алтны агуулгын хүлээгдэж буй хамгийн бага хэмжээнд тулгуурласан) худалдан авалтын гэрээнд заасны дагуу тухайн бүтээгдэхүүнийг гаалийн ажилтан, эрх бүхий тээвэр зуучлалын компани, эсвэл экспортын төлөөлөгч хүлээн авч баталгаажуулсан буюу гаалийн бүрдүүлэлт хийгдсний дараагийн ажлын өдөрт багтааж төлөх ёстой.

Төлбөр тооцооны эцсийн үлдэгдэл болон Шударга олборлолтын шагналыг талууд бүх зүйлийг (үнэ, сорьцын үр дүн) батлан хүлээн зөвшөөрч, сүүлчийн нэхэмжлэх ба бүх шаардагдах баримт бичгийг хүргүүлсэн өдрийн дараагийн ажлын өдөрт багтаж төлөх ёстой. Хоёр тал төлбөрийн өөр нөхцлийг гэрээгээр харилцан тохирч болно.

Худалдан авагч нь үнээс гадна Шударга олборлолтын шагнал олгох ба шагналыг дараах байдлаар тогтоосон байна:

- Нэг килограмм Шударга олборлолтын алт тутамд 4,000 ам.доллар,
- Нэг килограмм Шударга олборлолтын мөнгө тутамд 100 ам.доллар,
- Нэг килограмм Шударга олборлолтын цагаан алт тутамд 4,000 ам.доллар.

Онцгой тохиолдлоор, аль нэг лиценз эзэмшигчтэй жилд 20 кг-аас дээш хэмжээний (өсөн нэмэгдэх дүнгээр) худалдаа хийхээр заавал биелүүлэх гэрээний үүрэг хүлээсэн бол Шударга олборлолтын шагналыг талуудын хооронд (БУБ ба лиценз эзэмшигч) харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

Хэрэв тухайн алт Экологийн алтны гэрчилгээ, тэмдэглэгээтэй бол түүнийг худалдан авагчид Шударга олборлолтын шагнал дээрээ нэмж Экологийн шагнал нэмж олгох ёстой. Экологийн шагналыг дараах байдлаар тогтооно:

- Нэг килограмм Шударга олборлолтын алт тутамд 2,000 ам.доллар
- Нэг килограмм Шударга олборлолтын мөнгө тутамд 50 ам.доллар
- Нэг килограмм Шударга олборлолтын цагаан алт тутамд 2,000 ам.доллар.

ХУУХ нь Шагналын түвшинг өөрчлөх эрхтэй бөгөөд ийм өөрчлөлт хийх шаардлагатай бол Шударга олборлолтын уурхай эрхлэгчид болон зах зээлийн төлөөлөгчидтэй харилцан тохиролцоно. Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид алтаа өөрсдөө худалдсан тохиолдолд Шагналын мөнгийг холбогдох БУБ-д тусд нь төлөх ёстой.

Хэрэв Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд хамрагдсан БУБ эсвэл бичил уурхайчид худалдааны эсвэл экспортын зөвшөөрөлгүй бол Шагналын төлбөр тооцоог хариуцан зуучлах үүргийг худалдааны эсвэл экспортын гэрээт үйлчилгээ үзүүлэгч гүйцэтгэнэ.

БУБ эсвэл ШОҮС-д хамрагдсан уурхайчид болон импортлогчийн хооронд харилцан тохирч уурхайчдад хохиролтой бус өөр зохицуулалт хийхээр сонгосноос бусад тохиолдолд экспортын цэгээс цааших тээвэрлэлтийн болон даатгалын зардлыг импортлогч хариуцах ёстой.

Шударга олборлолтын гэрчилгээтэй металлын бүх борлуулалтын гүйлгээг ХУУХ-ны мэдээллийн системд бүртгүүлж, барааны урсгалын

тайлан болон аудитын зорилгод ашиглуулах ёстой. Эхний худалдан авагч нь худалдан авсан нэг килограмм Шударга олборлолтын алт тутамдаа “Шударга олборлолтын хөгжлийн хураамж” төлнө. Хэрэв Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд хамрагдсан БУБ эсвэл бичил уурхайчид худалдааны чиг үүрэг эсвэл экспортын зөвшөөрөлгүй бол холбогдох худалдаа, экспорт, гарал үүслийн хяналттай холбоотой бүх шаардлагыг хэрэгжүүлж БУБ-ын нэрийн өмнөөс, БУБ-ын чиг үүргийн дагуу хариуцаж ажиллах гуравдагч талын оператор буюу үйлчилгээ үзүүлэгчтэй (орон нутгийн худалдаачин байж болно) гэрээ байгуулан ажиллаж болно. Энэхүү үйлчилгээ үзүүлэгч нь БУБ-д тавигдах гарал үүслийн хяналт, тайлагналын бүхий л шаардлагыг даган мөрдөж, аудит хийлгэдэг байх шаардлагатай.

Шударга олборлолтын алттай хамтран ажиллаж хөгжлийн хураамж төлсөн ХУУХ-ны тусгай зөвшөөрөл эзэмшигчид Шударга олборлолтын лицензийн нэмэлт төлбөр төлөлгүйгээр Шударга олборлолтын тэмдэг ашиглах эрхтэй байна.

Худалдааны харилцаа ба гэрээнүүд: Үйлдвэрлэгчид болон худалдан авагчид буюу шагнал төлөгчдийн хооронд тодорхой дүрэм, нээлттэй арилжих худалдан авалтын төлөвлөгөө, үйлдвэрлэлийн төлөвлөгөөтэйгээр урт хугацааны харилцаатай ажиллах нь энэхүү хоёр талын итгэлцэлийн харилцааг бэхжүүлж, БУБ үйл ажиллагаагаа урт хугацаанд сайжруулах боломжтой болгодог. Түүнчлэн гэрээнд оролцогч талууд гэрээгээр хүлээх үүргээ харилцан тохиролцож, сайтар баримтжуулан, сайн ойлгож ухамсарласан байх нь чухал.

БУБ (эсвэл Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид) болон худалдан авагч талууд тухайн салбарт мөрдөгдөж буй практикт нийцүүлэн худалдан авалтын гэрээндээ алтны агуулга тодорхойлох, арбитраар маргаан шийдвэрлүүлэх журмуудаа тодорхойлж өгөх ёстой. Шударга олборлолтын гүйлгээ бүрийн ил тод байдал, гарал үүслийн хяналтын шаардлагыг баталгаажуулахын тулд бүх оролцогч талууд холбогдох гэрээнд өөрсдийн гарын үсгийг зурсан байх ёстой.

БУБ (эсвэл Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид) болон худалдан авагч талын хооронд

Шударга олборлолтын гүйлгээ бүртээ гэрээ байгуулж байх ёстой. Энэхүү гэрээ нь хамгийн багадаа дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

- Хамгийн их ба хамгийн бага хэмжээ,
- Чанарын үзүүлэлт,
- Үнэ ба төлбөрийн нөхцөл,
- Хүргэлтийн нөхцөл (хугацаа, хүргэх газар),
- Урьдчилгаа төлбөрийн тухай тохиролцоо (дор үзнэ үү)

Оролцогч талууд үнээ Лондоны Алтны Биржийн Холбооны хэдний өдрийн үдээс өмнөх эсвэл үдээс хойших ханшид тулгуурлан тогтоохоо тохиролцох ёстой.

Аль нэг БУБ эсвэл худалдан авагчийг түдгэлзүүлэх мэдэгдэл гаргасан тохиолдолд тухайн мэдэгдэл гарсан өдрөөс өмнө гарын үсэг зурсан гэрээнүүд энэ хугацаанд гэрчилгээ авсан бүтээгдэхүүнийг дээд тал нь зургаан сарын хугацаагаар төлөөлнө гэж үзнэ.

ХУУХ нь ийнхүү эрх нь түдгэлзсэн БУБ, операторууд, лиценз эзэмшигчдийн жагсаалт гаргаж Шударга олборлолтын мэдээллийн системээр дамжуулан мэдээлнэ. Нийт операторууд, БУБ-ууд хэдийд ч ХУУХ-нд хандаж бизнесийн түншүүдийнхээ эрхийн статусыг шалгаж болно.

Гэрчилгээ нь хүчингүй болсон оператороос тухайн хүчингүй болсон өдрөөс эхлэн бусад операторууд баталгаажсан бүтээгдэхүүн худалдан авах, худалдахгүй байх ёстой. Худалдан авагчид хүргэгдсэн бүх гэрээг хүлээн зөвшөөрөх ёстой. Харин худалдан авагчид хараахан хүргэлт хийгдээгүй гэрээг хүчин төгөлдөр Шударга олборлолтын гэрээ гэж үзэхгүй байх ёстой.

Аливаа худалдан авагч ямар нэг БУБ-тай бизнесийн харилцаа тогтоож ажилласнаас хойш 3 жилийн дараа БУБ бүрээс ямар хэмжээний Шударга олборлолтын алт худалдан авахаа тодорхойлсон Худалдан авалтын жилийн тодотгол¹¹ төлөвлөгөө гаргаж бизнесийн

¹¹Тодотгол гэдэг нь тодорхой нэг худалдан авагчийн ямар нэг БУБ-аас дараагийн жилийн турш худалдан авах бүтээгдэхүүний тооцоолсон хэмжээ.

түншүүд болон ХУУХ-нд өгөх ёстой. Мөн шаардлагатай бол харилцан итгэлцэл, шууд харилцаанд тулгуурлан тухайн худалдан авалтын тодотгол төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно.

Урьдчилгаа төлбөр: БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид тодорхой хэмжээнд бие даасан байдалтай байж, уламжлалт хараат байдал буюу “эдийн засгийн мөлжлөг”-ын хэлбэрээс салахад урьдчилгаа төлбөр чухал үүрэгтэй.

БУБ буюу Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид урьдчилгаа төлбөрийн санг удирдах ил тод механизмтай байх бөгөөд маргаан шийдвэрлэх зорилготой урьдчилгаа төлбөрийн сангийн ашиглалтад санхүүгийн аудит хийлгэхийг бичгээр зөвшөөрсөн байна. Урьдчилгаа төлбөрийн шаардлагатай холбоотой зөрчил маргаан гарсан тохиолдолд орон нутгийн болон үндэсний хууль тогтоомжийн шаардлагыг баримтлана.

БУБ буюу Шударга олборлолтын Үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид болон худалдан авагчийн хооронд урьдчилгаа төлбөртэй холбоотой хоорондын тохилцооны талаар стандартын болон тухайн орны хууль журмын дагуу нарийн тусган зохицуулсан байна.

БУБ буюу Үйлдвэрлэлийн систем ба Эрх бүхий анхны худалдан авагчийн хүрээнд худалдааны шинэ харилцаа тогтоож байгаа үед худалдан авагчид болон БУБ буюу Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчдын хооронд туршилтын хугацааг хэлэлцэн тохирч, туршилтын хугацаа нь хоёр удаагийн бараа ачилтаас хэтрэхгүй, эсвэл хоёроос доош гүйлгээ хийгддэг тохиолдолд нэг жилээс хэтрэхгүй байна.

Урьдчилгаа төлбөрийн санхүүгийн хураамж нь худалдан авагчийн эх оронд бизнесийн амжилт сайтай яваа компанид банкнаас олгох зээлийн хүү дээр зээлийн даатгалын зардал, захиргааны зардлын 1%-г нэмсэн дүнгээс хэтрэхгүй байх ёстой. Урьдчилгаа төлбөрийн санхүүгийн төлбөрийг нээлттэй байдлаар хэлэлцэн тохирч тайлагнах ёстой.

БУБ буюу Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчдын зүгээс гаргасан урьдчилгаа төлбөрийн хүсэлт нь ачилт бүрийн үнийн дүнгийн 60%-иас хэтрэхгүй байна. Туршилтын үе амжилттай өнгөрсний дараа худалдан авагчаас худалдагч талын хүссэн үнийн дүн үнийн дүнгийн 40%-иас доошгүй бол хүссэн хэмжээнээс доошгүй хувийн урьдчилгаа төлбөр олгоно.

БУБ буюу Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчдын зүгээс гаргасан урьдчилгаа төлбөрийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зориулалтаар ашиглах бөгөөд хүсэлтэнд уг төлбөрийг ашиглах зорилго, бүтээгдэхүүн нийлүүлэх хугацааг заасан байх шаардлагатай.

Боловсруулалт, худалдаа, тээврийн нийлүүлэлтийн суваг дахь гарал үүслийн хяналт: Жинхэнэ шударга олборлолтын алтыг баталгаажуулах нь чухал бөгөөд энэ нь гарал үүслийн бүртгэл хөтлөлт болон БУБ –ын ДХС-ийг хангангалттай түвшинд хэрэгжүүлэхтэй холбоотой.

БУБ буюу Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид болон Эрх бүхий анхны худалдан авагчын хооронд хийсэн бүх гүйлгээ биетээр хяналт тавих боломжийн шаардлагуудад бүрэн нийцсэн байна.

Шударга олборлолтын гарал үүслийн хяналтын шаардлагыг зохих төрлөөр нь зөв тавьж байгаа тохиолдолд Шударга олборлолтын алтны хэмжээг аль ч шатанд нийлүүлэх, холих, нэгтгэх боломжтой байна.

Энэ нь Шударга олборлолтын алт ба Экологийн шударга олборлолтын алтны аль алинд хамаарна. Экологийн шударга олборлолтын алтыг жирийн Шударга олборлолтын алттай нийлүүлж, хольж, нэгтгэсэн тохиолдолд үүсэх бүтээгдэхүүн ямагт ердийн Шударга олборлолтын алтанд тооцогдоно.

Операторуудын хооронд хийгдэж байгаа бүх гүйлгээ, түүний дотор тээвэр, аль нэг оператор эсвэл түүний туслан гүйцэтгэгчийн хийсэн ажил зэрэг нь цэвэршүүлэх ажиллагааны цэг хүртэлх биет хяналтын шаардлагыг бүрэн хангаж байх ёстой.

Эрх бүхий цэвэршүүлэгчээс цааших Шударга олборлолтын систем нь “Шударга олборлолтын нэгтгэл” ба “Шударга олборлолтын тэмдэг” гэсэн хоёр загварыг санал болгодог бөгөөд эдгээр нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлын дагуу сонгодог нийлүүлэлтийн сувгийн хоёр өөр боломж юм.

“Шударга олборлолтын тэмдэг” загварын бүтээгдэхүүний хувьд операторуудын хооронд хийгдэж байгаа бүх гүйлгээ, түүний дотор тээвэр, аль нэг оператор эсвэл түүний туслан гүйцэтгэгчийн хийсэн ажил зэрэг нь гарал үүслийн биет хяналтын шаардлагыг бүрэн хангаж байх ёстой.

“Шударга олборлолтын тэмдэг” загварын бүтээгдэхүүний хувьд нийлүүлэлтийн сувгийн аль ч цэгт байгаа аль ч оператор бүх баримт бичиг дээр өөрийн таних тэмдгийг тавих замаар баримт бичгийн хянах боломжийг бий болгох ёстой.

Бүх оператор болон гэрчилгээ олгогч байгууллага өөрөө дараах мэдээллийг хянах боломжтой байх нөхцлийг бүрдүүлэх ёстой:

- Тухайн бүтээгдэхүүнийг худалдан борлуулагч
- Тухайн бүтээгдэхүүний гүйлгээ хийх (худалдах, худалдан авах) үеийн биет байдал
- Хийгдсэн өөрчлөлтүүд ба холбогдох гарц
- Хаягдал
- Худалдсан ба худалдан авсан хэмжээ (нэг дээш – нэг доош)
- Гүйлгээ хийгдсэн огноо
- Шударга олборлолтын доод үнэ, Шударга олборлолтын шагналын төлбөр, Экологийн шагнал, урьдчилгаа төлбөр (шаардлагатай бол) зэрэг төлбөрүүд

2.8.2 Шударга олборлолтын гэрчилгээний загварт хэрэглэгдэх стандартын үзүүлэлт

Шударга олборлолтын гэрчилгээний загварын зорилго:

Шударга олборлолтын Гэрчилгээний загвар нь аливаа БУБ олборлосон алтаа Шударга олборлолтын эрх бүхий нийлүүлэлтийн биет сувгаар дамжуулан худалдах (Fairmined Incorporated эсвэл

Labeled загвараар) боломжгүй эсвэл эдийн засгийн хувьд ашиггүй нөхцөл байдалд зориулагдсан байдаг.

Зах зээлийн энэхүү загвар нь улс орон бүр өөрийн онцлогт тохирсон хууль ёсны нийлүүлэлтийн сувагтай байхыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд зарим тохиолдолд үндэсний лиценз, зөвшөөрөл бүхий хууль ёсны худалдан авагчид байгаа нөхцөлд БУБ-ууд дотоодын нийлүүлэлтийн сувагт бүтээгдэхүүнээ борлуулах нь илүү ашигтай бөгөөд тааламжтай байж болохыг хүлээн зөвшөөрдөг нь БУБ-ууд Шударга олборлолтын системд оролцож үр шимийг нь хүртэх боломж олгосон шийдэл юм.

Шударга олборлолтын Гэрчилгээ нь гэрчилгээтэй алтыг (өөрөөр хэлбэл, биет хяналтын шаардлага хангасан, тодорхой нийлүүлэлтийн сувгаар дамжсан) худалдан авахад анхаарахаасаа илүү БУБ-аас үйлдвэрлэсэн гэрчилгээжсэн алт ба алтны нийлүүлэлтийн хууль ёсны сувагт орох урсгалд тулгуурлан баталгаажсан алттай адилтгах хэмжээний шагнал олгодог. Энд Шударга олборлолтын гэрчилгээ бүхий бүхий алтыг Эрх бүхий худалдан авагчид борлуулах ажиллагаа явагдахгүй учраас алтны гүйлгээг (дотоодын хууль ёсны худалдан авагчид худалдсан) Шагналын төлбөрөөс салгаж (шагналыг Гэрчилгээжсэн эрх бүхий худалдан авагч олгодог), тухайн алтыг СТАНДАРТ-д Шударга олборлолтын бус нийлүүлэлтийн сувгаар (" хууль ёсны нийлүүлэлтийн бусад сувагт борлуулах) худалдан борлуулахыг зөвшөөрдөг. "Хууль ёсны бусад сувагт худалдсан алт"-д Шударга олборлолтын доод үнэ хамаарахгүй.

Гэрчилгээ бүхий баталгаажсан алтаа хэсэгчилэн буюу бүгдийг Шударга олборлолтын гэрчилгээтэйгээр худалдахыг хүссэн БУБ-ууд Шударга олборлолтын алтны борлуулалтаа ХУУХ-ны Шударга олборлолтын мэдээллийн системд бүртгүүлэх ёстой.

Хэрэв БУБ гэрчилгээнүүдээ Шударга олборлолтын мэдээллийн системд бүртгүүлсэн бол БУБ-аас Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт биетээр нийлүүлж буй (Incorporated эсвэл Labeled байдлаар) бүх алтны борлуулалтыг Шударга олборлолтын мэдээллийн системд оруулах ёстой.

ХУУХ нь Шударга олборолтын алтаа нийлүүлэлтийн сувагт нь биетээр нийлүүлэх сонирхолгүй боловч хариуцлагатай бичил уурхайчид, тэдний хамтын нийгэмлэгийг дэмжихэд хувь нэмэр оруулах хүсэлтэй оролцогчдод Шударга олборлолтын гэрчилгээгээ худалдан борлуулж, Шударга олборлолтын шагнал болон хөгжлийн хураамжийг нэмэхмжлэх ёстой.

3.1 Шударга олборлолтын стандартын зах зээл

Зорилго: Шударга олборлолтын гэрчилгээний схем, түүний үр өгөөжийг улам олон тооны хариуцлагатай бичил уурхайчдад хүргэж өргөжүүлэх, түүнийг урт хугацаанд хэрэгжих боломжтой болгохын тулд уурхайчдын зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зах зээлийн хавсралтын хамрах хүрээ: Бичил уурхайгаас олборлосон алт болон дагалдах үнэт металлын Шударга олборлолтын стандартын Зах зээлийн хавсралт нь үнэ ба шагналын төлбөр хийгдэх цэгээс хойш оролцож буй нийлүүлэлтийн сувгийн бүх оператор, лиценз эзэмшигчдэд хамаардаг.

Шударга олборлолтын системээс Шударга олборлолтын БУБ-даас худалдан авч буй алтны хэмжээг нэмэгдүүлэн зах зээлийн илүү тогтвортой өсөлтөд хүрэхийн тулд өөр өөр зах зээлд зориулсан, биетээр гарал үүслийн хяналт тавьж болохуйц худалдааны боломжуудыг санал болгож байна.

1. **“Шударга олборлолтын нэгтгэл”-ийн** загвар нь Шударга олборлолтын стандартын дагуу гарал үүслийн биет хяналтыг нийлүүлэлтийн сувгийн алт цэвэршүүлэх шат хүртэл тавьдаг загвар юм. Үүнээс цааших хяналт нь операторууд, лиценз эзэмшигчдийн шаардлагын дагуу явагдах бөгөөд тэд өөрсдийн сонгосон бүтээгдэхүүний хяналтын дүрмийг хэрэглэдэгээрээ лицензийн эрх бүхий бизнесүүд, брэндүүд баталгаажсан алтыг худалдан авч хууль ёсны, эрх бүхий нийлүүлэлтийн сувагт оруулан өөрийн биет хяналтыг тавих, сонгосон нийлүүлэлтийн системдээ оруулах, компанийхаа шошго тэмдгийг тавих зэргээр өөрийн хэрэгцээ шаардлага тохируулан уян хатан хэрэглэх боломж олгодог.

Гарал үүслийн хяналт: Шударга олборлолтын эрх бүхий алт цэвэршүүлэгчээс цааш хариуцан борлуулж байгаа алтны операторууд, лиценз эзэмшигчид Шударга олборлолтын алтыг өөр ямар нэг хууль ёсны нийлүүлэлтийн сувагт оруулах эсэхээ чөлөөтэй шийдэж тодорхойлох боломжтой. Мөн бусад үйлчлүүлэгчээс тавьсан жинхэнэ эсэх тухай шаардлагад хариулах боломжтой байхын тулд баримт бичгийн хяналт тавьж байх ёстой.

Нийлүүлэлтийн сувгийн дагуух бүх оператор, лиценз эзэмшигчид ХУУХ-нд бүртгүүлж, Шударга олборлолтын мэдээллийн системд тайлангаа өгдөг байх ёстой. Тэд энэхүү Шударга олборлолтын стандартын Зах зээлийн хавсралтын шаардлагад нийцэж байгаа эсэхээ үнэлэхийн тулд аудит хийлгэнэ.

Магадлагаа: Лиценз эзэмшигчийн нийлүүлэлтийн сувагт Шударга олборлолтын алтыг нэгтгэхтэй холбоотой магадлагаа гаргахад баримтлах дүрмүүд нь хэрэглэгчид болон бусад бизнесүүд үнэн зөв мэдээлэл мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ загварын дагуу магадлагааг компаний нийгмийн хариуцлагын болон тогтвортой байдлын тайлангийн түвшинд гаргаж болох бөгөөд “Шударга олборлолтын алт”, эсвэл “Экологийн шударга олборлолтын алт”-аар хийгдсэн хэрэглээний тодорхой бүтээгдэхүүнд хамаарахгүй. Эцсийн магадлагаа нь өгөгдсөн хуанлийн жилд төлсөн Шагналын хэмжээ, худалдан авсан Шударга олборлолтын алтны хувь хэмжээ, эзлэх хувийг илэрхийлж болно. Шударга олборлолтын алтыг бусад эх үүсвэрийн алттай харьцуулсан хувь хэмжээний хувьд үнэн зөв тооцоо хийхэд зориулсан нотлох баримттай байх ёстой. Эхний 0 жилийн магадлагааны талаар Шударга олборлолтын алтны төлөвлөсөн эсвэл амласан худалдан авалтын хэсэгт хандана. Шударга олборлолтын алт ба Шударга олборлолтын тэмдгийг лиценз эзэмшигчид компаний түвшинд ашиглахыг дэмждэг боловч “Шударга олборлолтын нэгтгэл” загварын дагуу хийгдсэн хэрэглээний эцсийн

бүтээгдэхүүнтэй холбоотой магадлагаа гаргахад зориулагдаагүй бөгөөд Шударга олборлолтын тэмдэг тавихгүй болно¹².

2. **“Шударга олборлолтын тэмдэг”**-ийн загвар нь “Шударга олборлолтын нэгтгэл”-ийн загварын хяналтын хүрээг өргөтгөсөн нийлүүлэлтийн сувгийн загвар юм. Энэ тохиолдолд бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч хүртэл нийлүүлэлтийн сувагт бүхэлд нь биетээр хяналт тавих боломжийг Шударга олборлолтын стандарт олгодог. Нийлүүлэлтийн сувгийн бүх операторууд Шударга олборлолтын гэрчилгээтэй, эрх бүхий лиценз эзэмшигчид байж, Шударга олборлолтын алтаа өөр бусад алтнаас бүрэн тусдаа байлгаж, Шударга олборлолтын бус эх үүсвэрийн бүтээгдэхүүнтэй жингийн хувьд нийлүүлэх эсвэл холихыг хориглодог. Тухайн алт нь биет байдал, гарал үүслийн хувьд Шударга олборлолтын гэрчилгээ бүхий үйлдвэрлэгчдээс гаралтай гэдгийг хэрэглэгчдэд батлаж Шударга олборлолтын тэмдэг бүхий хэрэглээний бүтээгдэхүүнд ХУУХ-ны шошго тэмдэг тавих зааврын дагуу Шударга олборлолтын гэрчилгээний тэмдэг, тэмдэглэгээ хийж болно.

Гарал үүслийн хяналт: Гарал үүслийн биет болон баримт бичгийн хяналтын шаардлага гэдэг нь тодорхой нэг бүтээгдэхүүн дэх тогтоосон хэмжээний Шударга олборлолтын алтыг нэг буюу түүнээс дээш тооны бичил уурхайн байгууллагаас (БУБ) Шударга олборлолтын стандартын дагуу олборлосон бөгөөд энэхүү хэрэглээний бүтээгдэхүүний худалдан авалт нь гэрчилгээ бүхий БУБ-уудад шууд үр өгөөжөө өгсөн гэдгийг хэрэглэгчдэд батлаж өгдөг. Гарал үүслийн шаардлагын хувьд Шударга олборлолтын нэгдэлийн шаардлагуудыг агуулахаас гадна дараах нэмэлт шаардлагуудыг тавьдаг.

ШОҮС-д оролцож буй бүх оролцогчид, операторын хувьд гарал үүслийн биет хяналт тавих шаардлагыг ямагт бүрэн дагаж мөрдөж байх ёстой.

¹²Шударга олборлолтын тэмдгийг мэдээлэл харилцааны зорилгоор ашиглах талаар ХУУХ-ны Шударга олборлолтын тэмдгийн гарын авлагаас үзнэ үү.

Бүх туслан гүйцэтгэгчид гарал үүслийн биет хяналтын шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой. Шударга олборлолтын оператор нь гарал үүслийн биет хяналт тавих боломжийг хангаж, тухайн операторын зүгээс туслан гүйцэтгэгч нарт аудит хийдэг байх үүрэгтэй.

Магадлагаа ба бүтээгдэхүүний бүтэц: Энэхүү стандартын хүрээнд зөвхөн Шударга олборлолтын алт ба дагалдах үнэт металлийг хамардаг бол, Шударга олборлолтын тэмдэг бүхий бүтээгдэхүүн нь уг металлийг агуулсан эцсийн хэрэглэгчийн бүтээгдэхүүн юм. Бүтээгдэхүүний бүтэц найрлагын дүрэм ёсоор тухайн эцсийн хэрэглээний бүтээгдэхүүн дэх үнэт металлын агуулга гэдэг утгаараа чанарын шаардлагыг тууштай хангаж, нийт операторууд, нэн ялангуяа хэрэглэгчдэд ил тод байх ёстой.

Хэрэв тухайн лиценз эзэмшигч нь аливаа нэг бүтээгдэхүүнд агуулагдаж буй Шударга олборлолтын алтны гарал үүслийн талаар тухайн бүтээгдэхүүн, сав баглаа боодол, худалдах цэг дээр магадлагаа гаргах тохиолдолд (тухайлбал, эд анги бүрийг тамгалах, хайрцаг дээр нь Шударга олборлолтын лого тавих, Шударга олборлолтын логотой гэрчилгээ өгөх, Шударга олборлолтын алтаар хийсэн гэдгийг тухайн худалдан авагчид мэдэгдэх гэх мэтээр) тухайн алт нь Шударга олборлолтоос эхлээд эцсийн бүтээгдэхүүн болох хүртэл бүх үе шатанд гарал үүслийн биет хяналт тавигдсан, Шударга олборлолтын бус эх үүсвэрийн алттай холилдоогүй байх хэрэгтэй.

Шударга олборлолтын тэмдэг бүхий эцсийн хэрэглээний бүтээгдэхүүний тэмдэг нь тухайн алт, мөнгө, эсвэл цагаан алт нь Шударга олборлолтын гэрчилгээтэй гэдгийг тодорхой харуулдаг байх шаардлагатай¹³.

Шударга олборлолтын алтны тэмдэгтэй байж болох эцсийн хэрэглээний бүтээгдэхүүнүүд:

- (i) Үнэт эдлэл, мөн бугуйн цаг гэх мэт үнэт эдлэлийн хагас боловсруулсан эд анги

¹³Шударга олборлолтын тэмдэг ашиглах талаар ХУУХ-ны Шударга олборлолтын тэмдгийн гарын авлагаас үзнэ үү.

- (ii) Дурсгалын болон санхүүгийн чанартай зоос, ембүү, алт мөнгөн эдлэл
- (iii) Медаль, цомууд
- (iv) Шашины эд өлгийн зүйлс
- (v) Алтан ялтас, уран сайхны, гар эсвэл механик аргаар алтаар бүрэх, электро, химийн аргаар алтдахад зориулсан алт

Шударга олборлолтын тэмдэг бүхий хэрэглээний бүтээгдэхүүн дэх алтны (Au) хамгийн бага сорьц 9 карат байна.

Шударга олборлолтын тэмдэг бүхий хэрэглээний бүтээгдэхүүн дэх мөнгөний (Ag) хамгийн бага цэвэршил 800 байна.

Шударга олборлолтын тэмдэг бүхий хэрэглээний бүтээгдэхүүн дэх цагаан алтны (Pt) хамгийн бага цэвэршил 850 байна.

Алтан гулдмайд агуулагдах алт нь 100% Шударга олборлолтын алт байна.

Шударга олборлолтын алт хэмээн худалдаалагдах алтан гулдмай (тухайлбал 18 карат алт) нь бүгд Шударга олборлолтын алт (Au) байх ёстой. Энэ нь Шударга олборлолтын мөнгө хэмээн худалдагдаж буй мөнгөн гулдмай, Шударга олборлолтын цагаан алт хэмээн худалдагдаж буй цагаан алтан гулдмайд мөн адил үйлчилнэ. Хэрэв Шударга олборлолтын алтан гулдмайд мөнгө эсвэл цагаан алт орох бол заавал Шударга олборлолтын мөнгө эсвэл цагаан алт ашиглах албагүй.

Шударга олборлолтын тэмдэг ашиглах эрхийг ХУУХ-ноос авна. Шударга олборлолтын алт ашигладаг, түүндээ “Шударга олборлолтын хөгжлийн хураамж” төлсөн ХУУХ-ны лиценз эзэмшигчид лицензийн нэмэлт хураамж төлөлгүйгээр Шударга олборлолтын тэмдэг ашиглах эрх олгоно.

Үнэт эдлэлийн хувьд Шударга олборлолтын сувгаас авах боломжгүй учраас урьдчилан бэлтгэсэн бэлдэц буюу эд ангийн агуулга нийт цэвэр алтны агуулгын 15% -иас хэтрэх ёсгүй. Үнэт эдлэл хийхэд ашигласан нийт алтны 85%-иас доошгүй нь гэрчилгээ бүхий баталгаажсан алтнаас бүрдсэн байна.

Энэ шаардлага нь бугуйн цагний механик эд ангид хамаарахгүй бөгөөд энэ тохиолдолд тухайн цагны гаднах гэр 100% Шударга олборлолтын алтаар хийгдсэн байна.

“Шударга олборлолтын алтаар өнгөлсөн, бүрсэн” гэсэн тэмдэг бүхий алтан хуудастай ном, наалт, хэрэглээний бүтээгдэхүүн өнгөлөх, бүрэхэд зориулсан алтан нунтаг, түүний дотор Экологийн алтаар хийсэн бүтээгдэхүүн нь 100% гэрчилгээ бүхий алт агуулсан байх ёстой. Алтны хайлшид Шударга олборлолтын гэрчилгээ бүхий мөнгө (Ag) эсвэл цагаан алт (Pt) оруулах эсэх нь үйлдвэрлэгчийн сайн дурын чөлөөт сонголт юм.

3. **“Шударга олборлолтын гэрчилгээ”** загварыг Шудрага олборлолтын систем нь Шударга олборлолтын алтыг нийлүүлэлтийн сувагтаа оруулах сонирхолгүй зах зээл эсвэл олборлосон алтаа Шударга олборлолтын сувагт биетээр худалдах боломжгүй эсвэл хүсэлгүй БУБ боловч хариуцлагатай бичил уурхайчид, тэдний хамтын нийгэмлэгийг дэмжихэд хувь нэмэр оруулах хүсэлтэй зах зээл, БУБ-д санал болгодог. Шударга олборлолтын гэрчилгээ бол тухайн БУБ-аас ямар нэг хууль ёсны худалдан авагчид худалдан борлуулж буй (нийлүүлэлтийн сувгийн энэ цэг хүртэл гарал үүслийн биет хяналтыг тавин) Шударга олборлолтын баталгаажсан алтыг “захиалж авах” схем юм.

“Шударга олборлолтын гэрчилгээ”-ний загвар нь Бичил уурхайн салбарыг санхүүгийн хувьд дэмжиж, хариуцлагатай бичил уурхайчид, тэдний хамтын нийгэмлэгийн хөгжилд хувь нэмрээ оруулах эрмэлзэл бүхий алтны салбарын дотоод, гадаад дах зах зээлийн өргөн хүрээтэй сегментүүдийг хамарсан уян хатан хэлбэрийг бий болгодог. Тус загвар нь баталгаажсан алтны худалдан авах эх үүсвэрт (өөрөөр хэлбэл, гарал үүслийн биет хяналт тавих боломж ба тодорхой нэг нийлүүлэлтийн сувагт борлуулах явдал) анхаарахаас илүү БУБ-аас нийлүүлж байгаа баталгаажсан алтны хэмжээ, түүний хууль ёсны нийлүүлэлтийн сувагт орох урсгалд тохирох хэмжээний шагналыг илэрхийлдэг.

Шударга олборлолтын эрх бүхий худалдан авагчид зарах ямар нэг гэрчилгээтэй алтны борлуулалт явагддаггүй (дотоодын хууль ёсны худалдан авагчид худалдсан) учраас алтны борлуулалтыг худалдан авагчийн төлсөн шагналын төлбөрөөс салгаж улмаар алтыг Шударга олборлолтын бус хууль ёсны нийлүүлэлтийн сувгаар борлуулах боломж олгодог байна.

Энэ загвар нь Шударга олборлолтын стандартын шаардлагад нийцсэн гэрчилгээ бүхий БУБ-дын алтны хариуцлагатай үйлдвэрлэлийг санхүүгийн хувьд дэмжих боломжийг тус салбарын дотоод, гадаадад байгаа байгууллага, хувь хүмүүст олгодог.

Гарал үүслийн хяналт: “Шударга олборлолтын гэрчилгээ” нь БУБ-аас Шударга олборлолтын стандартын дагуу үйлдвэрлэж, алтны нийлүүлэлтийн өөр хууль ёсны сувагт борлуулсан гэрчилгээтэй алтанд хамаардаг.

Шударга олборлолтын гэрчилгээнийхээ борлуулах хэмжээг нарийн гаргаж гэрчилгээ бүхий БУБ-дын үйлдвэрлэлийн хүчин чадал, төсөөлөл, борлуулалтын тоо баримтыг (нэхэмжлэх) Шударга олборлолтын мэдээллийн системд бүртгүүлдэг. Гэрчилгээ борлуулагдсны дараа түүнтэй адилтгах хэмжээний урамшууллыг БУБ эсвэл БУБ-уудад олгож, улмаар системд байгаа гэрчилгээний хэмжээнд зохих өөрчлөлт оруулна. Энэ загварт БУБ баталгаажсан алтаа ямар нэг хууль ёсны нийлүүлэлтийн сувагт борлуулах цэг хүртэл гарал үүслийн биет хяналт тавигддаг.

Эцсийн хэрэглэгчээс бусад Шударга олборлолтын гэрчилгээний бүх худалдан авагчид Шударга олборлолтын мэдээллийн системд бүртгүүлж, Шударга олборлолтын лиценз эзэмшигч болох ёстой.

Тэд Шударга олборлолтын гэрчилгээ худалдан авсан тухай магадлагаатай холбоотой аудитад орж болно.

Магадлагаа: Энэ загварын дагуу магадлагааг зөвхөн компани, компаний нийгмийн хариуцлага, тогтвортой байдлын тайлангийн түвшинд хийж болох бөгөөд хэрэглээний тодорхой бүтээгдэхүүнд “Шударга олборлолтын алт” эсвэл “Экологийн шударга олборлолтын алт”-аар хийсэн гэдэг үүднээс хандах ёсгүй.

Энэ гурван загвар бүгд Шударга олборлолтын стандартын шаардлагуудын дагуу гэрчилгээжсэн БУБ-дын зүгээс явуулж буй алтны хариуцлагатай үйлдвэрлэлийг дэмждэг.

БУБ-дын хувьд зах зээлийн аль загварт оролцож байгаагаас үл хамааран Шударга олборлолтын стандартын шаардлагуудыг¹⁴ холбогдох шаардлагуудыг нэгэн адил дагаж мөрдөх ёстой.

3.2 Нэр томъёоны хавсралт

Хүчлээр уусган хатаах (ХУХ):

Хүчлээр уусган хатаах (ХУХ) арга нь хүхэрлэг ашигт малтмалыг хүчилтөрөгчөөр исэлдүүлэх замаар тухайн ашигт малтмал агуулсан чулуулгыг агаар, усанд уусган ууршуулж хүхрийн давхар исэл гаргаж авах байгалийн урвал юм. Уул уурхайгаас үүдсэн ХУХ үйл явц нь уурхайн хаягдал хүдрийн овоолго эсвэл хаягдал шаарны цөөрөмд явагдаж болно.

Хайлш:

Хоёр буюу түүнээс дээш тооны металлийг эсвэл нэг металлийг өөр нэг металл бус бодистой хольж хайлуулах замаар гаргаж авсан хүссэн хэмжээний хатуулаг, хөнгөн, бат бөх чанартай бүхий металл бодис. Үнэт эдлэл дэх алтны сорьц буюу цэвэр алтны агуулгыг каратаар илэрхийлдэг. 24 карат алтыг (24К буюу 24 кт) алтыг цэвэр алт гэж нэрлэх бөгөөд 18 карат алт нь 75 хувийн ($18/24 \text{ карат} = 0,75$) алт агуулсан хайлш байна.

Бариулах:

Мөнгөн ус ашиглан хүдэр дэх алтны жижиг хэсгүүдийг нэгтгэн хайлш болгон бөөгнүүлж “мөнгөн усны нэгдэл” (алт мөнгөн усны холимог) үүсгэн улмаар мөнгөн усыг ууршуулж алтыг ялган авдаг ашигт малтмал боловсруулах арга.

¹⁴Худалдааны харилцаа бүлэгт заасан онцгой тохиолдлын шаардлагууд үйлчлэх ба хэрэглэж буй зах зээлийн загвараас хамааран өөр шаардлага тавигдаж болно.

Бичил уурхайн байгууллага (БУБ):

БУБ бол хариуцлагатай бичил уурхай эрхлэх, удирдан зохион байгуулах зорилгоор байгуулагдсан, тухайн улс орны эрх зүй, нийгэм, соёл, зохион байгуулалтын бодит байдалд нийцүүлэн үүсгэн байгуулсан албан ёсны байгууллага юм.

Дагалдах үнэт металл:

БУБ-ын ашигт малтмалын орд газраас илэрч, БУБ-ын олборлолтын үйл ажиллагаагаар гаргаж авсан мөнгө болон цагаан алтны бүлгийн метल्लीуд ("платинум").

Нутгийн ард иргэдийн бүлэгт тулгуурласан бичил уурхайчид:

Уул уурхайн үйл ажиллагааны ард хөдөлгөгч хүч болон ажилладаг, хамтын эзэмшлийн нутаг дэвсгэрийнхээ ашигт малтмалын нөөцөд тулгуурлан амьжиргаагаа залгуулдаг нутгийн хүн ам.

Баяжмал:

Боловсруулсан ашигт малтмалын хүдрээс гаргаж авсан алтны өндөр агуулга бүхий завсрын бүтээгдэхүүн.

Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэл бүхий газар:

Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэл бүхий газар – гэдэг нь зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэл, түүний дотор гэмт хэргийн сүлжээнээс гаралтай хүчирхийлэл газар авсан эсвэл ард иргэдэд ноцтой, өргөн хүрээтэй хор хохирол учруулахуйц бусад эрсдэлтэй газруудыг хэлнэ. Алт олборлолт, тээвэрлэлт, худалдаа, хадгалалт, экспортоор дамжуулан төрийн бус зэвсэгт хүчин, улсын эсвэл хувийн аюулаас хамгаалах хүчнүүдийг "шууд ба шууд бусаар дэмжих" гэдэгт төрийн бус зэвсэгт бүлэглэлүүд, тэдний харъяа дараахь хүмүүст ашигт малтмал нийлүүлэх, төлбөр төлөх, ачаа тээврийн эсвэл тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэхийг хэлэх ба үүгээр хязгаарлагдахгүй:

- i. Уурхайн газар нутагт хууль бусаар хяналт тавьдаг эсвэл тээврийн зам, алт худалддаг газар болон нийлүүлэлтийн сувгийн боловсруулалтаас өмнөх шатанд хяналт тавьдаг хүмүүс;

- ii. Уурхайд нэвтрэх үүд, тээвэрлэлтийн зам дагуу, эсвэл алт худалддаг газар хууль бусаар татвар авдаг буюу хүчээр мөнгө хураадаг хүмүүс;
- iii. Дундын зуучлагч нар, экспортын компаниуд, олон улсын худалдаачдаас хууль бусаар татвар авдаг буюу хүчээр мөнгө хураадаг хүмүүс.

Хүүхдийн эрхийн конвенци (НҮБ)¹⁵:

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн ерөнхий зарчмыг 2, 3, 6, 12 дугаар зүйлээс үзэж болно:

2 дугаар зүйл: Үл ялгаварлан гадуухалт: Бүх эрх нийт хүүхдэд адил тэгш үйлчилнэ. Төрөөс хүүхдийг аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхлаас хамгаалж, тэдний эрхийг хөхиүлэн дэмжих эерэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

3 дугаар зүйл: Хүүхдийн дээд эрх ашиг –Хүүхэдтэй холбоотой аливаа үйл ажиллагаа нь түүний эрх ашгийг дээд зэргээр хангах ёстой. Эцэг эхчүүд хүүхдэд хангалттай анхаарал халамж тавих үүрэгтэй бөгөөд ингэж чадаагүй үед төрөөс хангалттай анхаарал халамж тавих ёстой.

6 дугаар зүйл: Эсэн мэнд амьдрал, хөгжил – Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах төрөлх эрхтэй бөгөөд төрөөс хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих нөхцлийг бүрдүүлж өгөх үүрэгтэй.

12 дугаар зүйл: Хүүхдийн үзэл бодол – Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг үзэл бодлоо хүүхдэд нөлөөлөх аливаа асуудал, дүрэм журамд тусгуулах эрхтэй.

Эмзэг экосистем:

Эмзэг экосистемд биологийн төрөл зүйлийн хувьд өндөр үнэ цэнэ бүхий газрууд, түүний дотор (i) Ховордсон амьтан, ургамалд чухал ач холбогдолтой амьдрах орчин; (ii) орон нутгийн шинжтэй, хязгаарлагдмал тархалт бүхий амьтан, ургамалд чухал ач холбогдолтой амьдрах орчин; (iii) нүүдлийн буюу бөөнөөр цугладаг

¹⁵Эх сурвалж: http://www.unicef.org/crc/index_30177.html [хандсан 2013 оны 4 дүгээр сарын 1]

амьтдын төвлөрөлийг дэмждэг дэлхийн хэмжээний ач холбогдолтой амьдрах орчин; (iv) аюул заналд ихээхэн өртөж буй, цорын ганц давтагдашгүй экосистем; (v) эволюцийн хувьслийн үндсэн үйл явцтай холбоотой газруудыг оруулна¹⁶.

Компаний нийгмийн хариуцлага¹⁷:

Компаний нийгмийн хариуцлага гэдэг бол компаниуд бизнесийн үйл ажиллагаа болон бусад оролцогч талуудтай харилцах харилцаандаа нийгмийн болон байгаль орчны асуудлыг нэгтгэдэг менежментийн үзэл баримтлал юм. КНХ-ыг ерөнхийд нь компани эдийн засаг, байгаль орчин, нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа тэнцвэртэй биелүүлэхийн (“Гурван давхар үр дүнгийн арга”) зэрэгцээ хувьцаа эзэмшигчид болон сонирхогч талуудын хүсэн хүлээсэн зүйлийг шийдвэрлэх арга гэж ойлгодог.

Цианиджуулалт:

Цианидын уусмалд алтыг уусгаад (цианидан уусгалт) дараа нь цайраар тунадас үүсгэх эсвэл идэхжүүлсэн нүүрстөрөгчөөр уусган эргэж задлах замаар уусмалаас алтыг ялгадаг уул уурхайн боловсруулалтын технологи.

Өрхийн үйлдвэрлэлийн нэгж:

Өрхийн үйлдвэрлэлийн нэгж гэдэг нь өрхийн эдийн засгийн нэг хэсэг жижиг цех, үйлдвэрийн газар бөгөөд хэмжээ, онцлог шинжээсээ үүдэн албан ёсны улсын бүртгэл, үйл ажиллагааны зөвшөөрөл, эсвэл хөдөлмөрийн үзлэг шалгалт шаарддаггүй байж болно. БУБ нь хамтран ажилладаг бүх Өрхийн үйлдвэрлэлийн нэгж, уурхайчдыг бүртгэж, тэдгээр нь БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд болон Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт харъяалагддаг эсэхийг заасан байх үүрэгтэй. Энэ тохиолдолд тэд гарал үүслийн хяналт, шагналын удирлага, холбогдох бүх шалгуур үзүүлэлтийг хангах ёстой. Өрхийн үйлдвэрлэлийн нэгжийн

¹⁶Эх сурвалж: http://www.ifc.org/wps/wcm/connect/bff0a28049a790d6b835faa8c6a8312a/PS6_English_2012.pdf?MOD=AJPERES (хандсан 2013 оны 7 дугаар сарын 10)

¹⁷Эх сурвалж: <http://www.unido.org/what-we-do/trade/csr/what-is-csr.html> (хандсан 2013 оны 7 дугаар сарын 10)

үйл ажиллагаанд оролцож буй бүх хүмүүс (хүүхдийн хөдөлмөрт тооцогдох наснаас дээш насны хүмүүс) уурхайчид байна. Эдгээр нэгжид ажиллаж буй өрхүүд, хүүхдүүдийн сайн сайхан байдал, хүүхэд хамгааллын асуудалд онцгой анхаарал тавих шаардлагатай.

Доре:

Алт бол угаасаа цэвэр элемент. “Доре” гэдэг нь алтны хүдрийг хайлуулж гаргасан гол төлөв мөнгөний хольцтой, цаашид дахин боловсруулалт хийх шаардлагатай металл хайлш юм. Үүнд цэвэршүүлэлт хийснээр өөр хольц, бусад металлуудыг ялган авч доод тал нь 99.5%-н цэвэршилттэй алт гаргаж авдаг. Иймд доре цутгамал гэдэг нь алт, мөнгөний хольцтой хагас цэвэр хайлш бөгөөд ихэвчлэн уурхай дээр гаргаж аваад цааш нь цэвэршүүлэх үйлдвэр рүү тээвэрлэн цэвэр алт гаргаж авдаг.

Доред эзлэх алт, мөнгөний эзлэх хувь янз бүр байж болно.

Овоолго:

Өнгөн хөрс, хаягдал хүдэр, хаягдал шаар эсвэл бусад боловсруулсан, боловсруулаагүй ашигт малтмалын үлдэгдлийг түр эсвэл байнга хаяж овоолдог газар. Овоолгод хаягдсан эрдэс материалууд үнэ цэнэтэй бүрэлдэхүүн хэсэг агуулсан эсвэл агуулаагүй ч байж болно.

Гадны үйлчилгээ үзүүлэгчид:

БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдаагүй боловч ашигт малтмалын олборлолтоос эхлээд алт БУБ-н гараас гарч Шударга олборлолтын эрх бүхий анхны худалдан авагчид (эсвэл Шударга олборлолтын гэрчилгээний хувьд дотоодын хууль ёсны худалдан авагч) шилжих хүртэл БУБ-ын үйлдвэрлэлийн үйл явцад тодорхой хэмжээгээр оролцдог БУБ-ын эзэмшлийн биш, түүний мэдэл хяналтад байдаггүй аж ахуй нэгж, хувь хүмүүс.

БУБ боловсруулалт, худалдаа зэрэг өөрсдөө хийх дотоод чадавхигүй, эдийн засгийн үр ашиг багатай үйл ажиллагааг гадны үйлчилгээ үзүүлэгчдэд хариуцуулдаг.

Шударга олборлолтын гэрчилгээ бүхий алт:

Шударга олборлолтын гэрчилгээ бүхий алт гэж энэхүү СТАНДАРТ-ын дагуу олборлож, боловсруулж, цэвэршүүлж, худалдсан алтыг хэлнэ.

Энэхүү баримт бичигт дурдсан “Шударга олборлолтын алт” нь гэрчилгээ бүхий үйлдвэрлэгчдээс нийлүүлсэн, Шударга олборлолтын Зах зээлийн хавсралтад заасан зах зээлийн боломжуудын аль нэгний дагуу худалдагдаж болох алтад хамаарна.

Дараахь нөхцлийг хангасан тохиолдод алтыг Шударга олборлолтын алт хэмээн гэрчилгээжүүлнэ:

- Гэрчилгээ бүхий БУБ-ын олборлолтын талбайд байрлах Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системээс гаралтай,
- БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид,
- БУБ-ын Дотоод хяналтын системээр гарал үүслийг бүрэн хянах боломжтой,
- Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан БУБ эсвэл уурхайчдаар дамжуулан худалдах боломжтой.

Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөө:

БУБ-ын Шагналын хорооноос боловсруулан гаргадаг БУБ-ын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон стратегийн удирдамж. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа БУБ-ын 3 түвшний үүрэг хариуцлагатай холбож өгөх хэрэгтэй бөгөөд БУБ-д Шагналын санг хүлээж авсны дараа хэрэгжүүлэх Шагналын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг чиглүүлж өгдөг.

Шударга олборлолтын шагналын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө:

Шагналын мөнгөөр санхүүжүүлэн тодорхой төслүүд хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө. Шагналын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь Шударга олборлолтын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн байна.

Шударга олборлолтын үйлдвэрлэлийн систем:

БУБ Шударга олборлолтын гэрчилгээ авахын өмнө аль олборлолтын газар, үйл явц, уурхайчдыг оруулах, оруулахгүйгээ шийдэх замаар Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийнхээ хамрах хүрээг тодорхойлдог. Үйлдвэрлэлийн систем бол нэгтгэх схем бөгөөд БУБ-ын олборлолтын талбайд ажиллаж буй уурхайчид анхнаасаа гэрчилгээжүүлэлтэд нэгдэн орохыг зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй тохиолдолд зөвшилцөлд хүрэх үйл явц байдаг.

Эрх бүхий анхны худалдан авагч:

БУБ-аас гэрчилгээ бүхий алт худалдан авахад шууд оролцож буй Шударга олборлолтын оператор. Эрх бүхий анхны худалдан авагч нь энэхүү СТАНДАРТ-ын Худалдааны харилцааны тухай бүлэгт заасан шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой.

Албадан хөдөлмөр:

ОУХБ-ын 29 дүгээр конвенци бол ОУХБ-ын 8 үндсэн конвенцийн нэг. Үүнд албадан хөдөлмөрийг “хэн нэгнээс ямар нэг шийтгэлээр сүрдүүлэн хүчээр хийлгэсэн, тухайн хүнд сайн дураар хийхийг санал болгоогүй бүхий л ажил, үйлчилгээ” гэж тодорхойлсон байдаг.

Хууль ёсны бусад нийлүүлэлтийн сувагт худалдсан алт

БУБ-аас бүтээгдэхүүнээ “Шударга олборлолтын нэгтгэл”, “Шударга олборлолтын тэмдэг” загварын дагуу Шударга олборлолтын алтны нийлүүлэлтийн сувагт борлуулах боломжгүй буюу борлуулах хүсэлгүй тохиолдолд тухайн улсад ийм бизнес эрхлэх зөвшөөрөл, бүхий шаардагдах үндэсний лицензийг авсан дотоодын буюу үндэсний худалдан авагчид борлуулсан Шударга олборлолтын гэрчилгээ бүхий алтны хэмжээг хэлнэ. Энэ хэмжээтэй адилтгах хэмжээний Шударга олборлолтын шагналыг “Шударга олборлолтын гэрчилгээ”-ний загвар бүхий зах зээлд олгодог.

Гомдол барагдуулах механизм:¹⁸

Гомдол барагдуулах механизм бол хувь хүмүүс, бүлгүүдийн зүгээс аливаа нэг үйлдвэрийн газрын тэдэнд үзүүлж байгаа нөлөө, түүний дотор хүний эрхийн асуудлаар гомдол гаргаж, эрхээ хамгаалуулахыг хүсэх зэрэг албан ёсны арга хэрэгсэл санал болгодог шүүхийн бус журам юм. Эдгээр механизм нь соёлын хувьд зохистой, эрхийн хувьд нийцтэй хөндлөнгийн оролцооны, яриа хэлэлцээрт суурилсан буюу бусад үйл явцыг ашиглаж болно. НҮБ-ын тодорхойлсноор аливаа гомдол барагдуулах механизм үр дүнтэй байхын тулд хууль ёсны, хүртээмжтэй, урьдчилан таамаглагдахуйц, адил тэгш, ил тод, эрхэд нийцсэн байхын зэрэгцээ тасралтгүй суралцах үйл явц байх хэрэгтэй.

Хүний наймаа:¹⁹

“Хүнийг биеэр худалдах” гэдэг нь хүнийг айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, эсвэл албадлагын бусад хэлбэр, хулгайлах, залилах, хуурч мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг ашиглах, хэн нэгэнд төлбөр, мөнгө өгч, авах замаар өөр нэг хүнийг хяналтдаа оруулах зөвшөөрөл авах зэргээр ашиглан мөлжих зорилгоор ажилд оруулах, тээвэрлэх, дамжуулан шилжүүлэх, нуун далдлах, хүлээн авахыг хэлнэ. Ашиглан мөлжих ажиллагаанд наад зах нь бусдын биеийг үнэлүүлэх болон бусад хэлбэрийн бэлгийн мөлжлөг явуулах, албадан хөдөлмөр, үйлчилгээ эрхлүүлэх, боолчлох, боолчлолтой төстэй байдалд оруулах, хүнд хүчир ажил хийлгэх, эд эрхтнийг нь авах зэрэг үйлдэл орно.

¹⁸Эх сурвалж: НҮБ-ын Бизнес, хүний эрхийн талаар баримтлах зарчмыг компаний судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд хэрхэн ашиглах вэ. Иргэний нийгмийн байгууллагуудын гарын авлага. Хандсан http://somo.nl/publications-en/Publication_3899/ (2013 оны 7 сарын 1)

¹⁹Эх сурвалж: Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенцийн нэмэлт болгож НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, 2000 оны 11 дүгээр сарын 15, Хаяг <http://www.unhcr.org/refworld/docid/4720706c0.html> [2013 оны 4 дүгээр сарын 1-нд хандсан]

Дотоод хяналтын систем (ДХС):

БУБ нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийг хамарсан Дотоод хяналтын системтэй байдаг бөгөөд ингэснээр Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт орж байгаа нийт бүтээгдэхүүний хэмжээ, борлуулалтыг бүрэн хянаж байдаг.

ДХС бол Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт борлуулж буй стандартын бус бүтээгдэхүүнээс сэргийлэх гол хэрэгсэл бөгөөд дараах төрлийн алтыг системээс хасдаг:

- Олборлосон уурхайчид эсвэл боловсруулагчид нь тухайн БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд ороогүй;
- БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан уурхайчид, боловсруулах нэгжээс үйлдвэрлэн гаргасан боловч БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн нутаг дэвсгэрээс гадуур олборлосон ашигт малтмал буюу хаягдал хүдэр.

Хууль ёсны худалдан авагч:

БУБ-аас Шударга олборлолтын гэрчилгээний загварын дагуу Шударга олборлолтын алтаа худалдаж байгаа дотоодын буюу үндэсний худалдан авагч. Хууль ёсны худалдан авагч нь уг бизнесийг эрхлэхэд шаардагдах бүхий л лиценз, зөвшөөрлийг эзэмшдэг байх ёстой.

Лиценз эзэмшигч:

Лиценз эзэмшигч гэдэг нь хэрэглэгчтэй нүүр тулан ажиллаж буй оператор (оператор гэснийг үзнэ үү) бөгөөд ХУУХ-ноос авсан зохих лиценз, тухайн зах зээлийн загварын (Шударга олборлолтын нэгтгэл, тэмдэг эсвэл гэрчилгээ) дагуу Шударга олборлолтын тэмдэг, холбогдох магадлагааг ашиглах эрхтэй оператор юм.

БУБ-ын гишүүд, хувьцаа эзэмшигч буюу эзэн:

БУБ өмчлөлийн өөр өөр хэлбэртэй байж болно. Түүний гишүүд, хувьцаа эзэмшигчид, эзэдийн дийлэнх нь бичил уурхайчид байдаг. Үйлдвэржсэн уурхайн компаниуд БУБ-ын хувьцаа эзэмшигч байж болохгүй.

Уурхайчин:

Ерөнхийдөө “уурхайчин” гэж бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаа ямар нэг (эрэгтэй, эмэгтэй) хүнийг хэлнэ.

Энэхүү СТАНДАРТ-ын хувьд “уурхайчин” гэдэг нэр томъёо нь БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдан ажиллаж буй бүх төрлийн хүмүүст хамаарна. Тэд эзэд, хувиараа ашигт малтмал олборлогчид, ашигт малмал сонгон авагчид, газар ухагчид байж болно.

Ашигт малтмал:

Уурхайгаас олборлож гаргасан бүх хад чулуу, хайрган материал. Ашигт малтмалыг эдийн засгийн үнэ цэнийн хувьд хүдэр ба хаягдал чулуулаг гэж ангилдаг.

Ашигт малтмалын боловсруулалт:

Хүдрийг задлаж алт буюу алтны баяжмал, хаягдал хүдэр болгон салгах техник үйл явц. Баяжмал, хаягдал хүдэр хоёрыг цаашид дахин боловсруулж болно. Алтыг ихэвчлэн доре хэлбэрээр гаргаж авдаг бөгөөд цэвэршүүлэлт хийх замаар дагалдах үнэт металлаас нь салгадаг.

Ашигт малтмал сонгон олборлогчид (гол төлөв эмэгтэйчүүд):

Ашигт малтмал сонгон олборлогчид нь ихэнх тохиолдолд хаягдал хүдрээс ашигт малтмал түүж авдаг эмэгтэйчүүд байдаг. Зарим тохиолдолд энэ бүлэгт өндөр настнууд, өсвөр насны хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг эрэгтэй хүмүүс ч орсон байж болно. Тэд ихэвчлэн уурхайн талбайд ил ажиллаж бага хэмжээний түүхий алт цуглуулж борлуулах, эсвэл өрх гэрийн хүрээнд боловсруулалт хийх (гол төлөв тээрэмдэх, алт бариулах замаар) ажиллагаа явуулдаг. Зарим тохиолдолд тэд цуглуулсан ашигт малтмалаа БУБ-ын бүртгэлтэй уурхайчид эсвэл боловсруулах цехэд нийлүүлдэг бөгөөд борлуулалтыг ихэвчлэн орон нутгийн түвшинд хийдэг.

Энэхүү СТАНДАРТ-ын нэг зорилго бол ашигт малтмал сонгон олборлогч эмэгтэйчүүд алтаа орон нутгийн худалдаачдад хямд

үнээр өгөхийн оронд Шударга олборлолтын зах зээлд борлуулах боломж олгох явдал юм. Иймд БУБ-ын зүгээс Ашигт малтмал сонгон олборлогчдыг Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд нэгтгэх бүхий л хүчин чармайлтыг гаргах ёстой.

БУБ-ын олборлолтын талбай:

Хуулийн нэр томъёогоор уурхай эрхлэх эрх эзэмшигч тухайн газрын хөрснөөс нь ашигт малтмал олборлох эрхтэй газрыг хэлнэ.

Энэхүү СТАНДАРТ-ын хувьд БУБ-ын олборлолтын талбай гэдэг нь БУБ ба түүний уурхайчдын эдийн засгийн үйл ажиллагаа явагддаг, БУБ (эсвэл түүний уурхайчид) ашигт малтмалыг ашиглах эрхтэй (уурхайн концессийн гэрээ, түрээсийн гэрээ, ашиглалтын гэрээ буюу үндэсний хууль тогтоомжид заасан үүнтэй адилтгах зохицуулалт), тухайн газрыг өмчилдөг эсвэл газрын эзэнтэй газар ашиглалтын гэрээ байгуулсан бүх газар нутгийг хэлнэ.

Уурхай эрхлэх эрх:

Аливаа хуулийн этгээд эсвэл хувь хүн тодорхой нэг газар нутгаас (хуулийн нэр томъёогоор олборлолтын талбай) ашигт малтмал олборлох эрх.

Оператор:

Нийлүүлэлтийн сувагт орж алт эсвэл алт агуулсан материал худалдаалдаг буюу хувирган шилжүүлдэг БУБ-аас бусад этгээд.

Хүдэр:

Алтыг эдийн засгийн хувьд ашигтай бөөгнөрлийн хэмжээнд агуулсан (агуулга), улмаар боловсруулалт хийхэд тохиромжтой ашигт малтмал (чулуулаг эсвэл элсэн хэлбэртэй).

***Хамгаалалттай газар нутаг:*²⁰**

Байгаль орчин, түүний дагалдах экосистемийн үйлчилгээ, соёлын үнэт зүйлсийг урт хугацаанд хадгалж хамгаалах зорилгоор

²⁰Эх сурвалж: НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Дэлхийн байгаль хамгаалалтын хяналтын төв, Н.Дадлий (ред) Хамгаалалттай газар нутгийн удирдлагын ангиллуудын хэрэглэх заавар.Швейцарь, 2008 онь хуудас 8-9. (сүүлд хандсан огноо: 2013 оны 6 дугаар сарын 1)

хууль тогтоомж болон бусад үр дүнтэй арга хэрэгсэлээр дамжуулан нийтээр хүлээн зөвшөөрч, тусгай зориулалт тогтоон, удирддаг тодорхой заагласан газар зүйн орон зай.

Бүртгэлтэй уурхайчид:

БУБ-ын хамрах хүрээнд буй бүх уурхайчид бүртгэлтэй байна (мөн тухайн олборлолтын талбайн хэмжээнд БУБ-ын 2 дугаар түвшний үүрэг хариуцлагын хүрээнд хамаарна). Үйлдвэрлэлийн системд (БУБ-ын 1 дүгээр түвшний үүрэг хариуцлага) хамрагдсан “бүртгэлтэй уурхайчид” л Шударга олборлолтын нийлүүлэлтийн сувагт бүтээгдэхүүн нийлүүлэхийг зөвшөөрдөг. БУБ нь Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системдээ энэхүү СТАНДАРТ-ын бүхий л шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

БУБ ашигт малтмалын олборлолтод оролцож байгаа боловч БУБ-ын сануулгыг үл харгалзан бүртгүүлэхээс татгалзаж, БУБ-ын тушаалыг дагаж мөрдөхгүй байгаа бүртгэлгүй уурхайчдын төлөө хариуцлага хүлээх ёсгүй. Ийм “бүртгэлгүй уурхайчид” нь БУБ-ын Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системийн бүрэлдэхүүнд орохгүй. БУБ бүртгэлгүй уурхайчдаас ашигт малтмал эсвэл алт худалдан авахыг зөвшөөрөхгүй, бүртгэлгүй уурхайчид Шагналын шийдвэрт оролцохгүй боловч БУБ нь уурхайн олборлолтын талбайд Шударга олборлолтын үндсэн зарчмууд зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Боловсруулалт хийж байгаа операторыг ч бас “уурхайчин” гэж үзнэ.

Нөхөн сэргээлт:

Газрыг бичил уурхай ажиллаж эхлэхээс өмнөх нөхцөл байдалд аль болох ойртуулж эсвэл уурхайн дараах газар ашиглалтын зорилгод тохиромжтой байдлаар нөхөн сэргээхийг хэлнэ.

Хаягдал хүдэр буюу шаар:

Алтыг эдийн засгийн бус баяжуулалтаар боловсруулсны дараа үлдэх завсрын буюу эцсийн бүтээгдэхүүн. Хаягдал хүдрийг хаягдлын далан эсвэл хаягдлын цөөрөм байдлаар хадгална. Зарим тохиолдолд хаягдал хүдрийг дахин боловсруулж үлдэж байгаа алтыг гарган авч болно. Энэ тохиолдолд Шударга олборлолтын үйлдвэрлэлийн

системд ашиглагдсан хаягдал хүдэрт гарал үүслийн хяналт тавигдаж, бүртгэл хийгдэх, бүх шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

НҮБХЭК-ийн Ерөнхий зарчмууд²¹:

Хүүхдийн эрхийн конвенци бол олон улсын хүний эрх, түүний дотор иргэний, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, соёлын эрхүүд болон олон улсын хүмүүнлэгийн хуулийг иж бүрэн хамруулсан анхны хэрэгсэл юм. Тус конвенцийн баримтлах зарчимд үл ялгаварлан гадуурхах, хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангах, эсэн мэнд амьдрах, хөгжих эрх, оролцох эрх багтдаг. Эдгээр нь бусад бүхий л эрхийг эдлэх үндсэн шаардлагыг төлөөлж байдаг. Энэхүү конвенцийн нэмэлт заалтууд (43-54 дүгээр зүйл) уг Конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч үздэг бөгөөд засгийн газрын болон олон улсын байгууллагууд хүүхдийн эрхийг хамгаалах талаар хэрхэн ажиллахыг тайлбарласан байдаг. Хаяг:

Хаягдал чулуулаг:

Алт агуулаагүй эсвэл эдийн засгийн хувьд ашигтай хэмжээний алтны агуулгагүй, байнга эсвэл түр байдлаар хаяж зайлуулсан ашигт малтмал (овоолгыг үзнэ үү).

Эмэгтэй олборлогчид:

“Ашигт малтмал сонгон олборлогчид”-г үзнэ үү.

Ажилчид:

“Ажилчид” гэдэг нэр томъёо нь цалин хөлс авч буй бүх ажилтанд хамаарна. Үүнд нүүдлийн, түр, богино хугацааны, улирлын чанартай, туслан гүйцэтгэгч, байнгын хөлсний ажилчид орно. Мөн Африкт байдаг “ухагч нар” багтана. Шударга олборлолтын үйлдвэрлэлийн системд хамрагдсан ажилчид, ашигт малтмал сонгон олборлогчид нь БУБ-ын Шударга олборлолтын шагналын хороонд өөрийн төлөөлөгчидтэй байх ёстой.

²¹Эх сурвалж: http://www.unicef.org/crc/index_30177.html [хандсан 2013 оны 4 сарын 1]

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд (ХХТХ)²²:

ОУХБ-ын 182 дугаар конвенцид тодорхойлсноор: тухайн ажлын шинж чанар эсвэл хийгдэх нөхцөл байдлаас үүдэн хүүхдийн бие махбодь, оюун санаа, ёс суртахууны сайн сайхан байдлыг алдагдуулахуйц “аюултай ажил”-г хэлнэ. Үүнд:

- (a) Хүүхдийн бие махбодь, сэтгэл зүй, бэлгийн дарамтад оруулах ажил;
- (b) Газар дор, усны гүнд, аюултай өндөрт эсвэл хязгаарлагдмал орон зайд хийгдэх ажил;
- (c) Аюултай машин техник, тоног төхөөрөмж, багаж зэвсэгтэй ажиллах эсвэл хүнд хүчир гар ажиллагаа орсон, хүнд ачаа тээвэрлэхтэй холбоотой ажил;
- (d) Эрүүл бус орчинд хийгдэх ажил, тухайлбал хүүхдийг аюултай, хорт бодис, үйл явцтай ажиллуулах, эсвэл эрүүл мэндэд нь хор хохирол учруулахуйц температур, дуу чимээ, чичирхийллийн түвшинтэй орчин байж болно;
- (e) Уртасгасан цагаар ажиллах, шөнийн цагаар ажиллах, ажил олгогчын байранд хүүхдийг үндэслэлгүйгээр хорьж саатуулдаг ажил гэх мэт онцгой хүнд хэцүү нөхцөлд хийгддэг ажил.

²²Эх сурвалж ОУХБ: <http://www.ilo.org/ipec/facts/WorstFormsofChildLabour/lang-en/index.htm> [хандсан 2013 оны 4 дүгээр сарын 2]

ХОЛБОО БАРИХ:

Монгол Улс, Улаанбаатар хот
Скай Плаза Бизнес төв
Элчингийн гудамж
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

 +976 11 328848

 +976 11 322415

 info@sam.mn

 www.sam.mn

 ASM Mongolia

 ASM_Mongolia

© Энэхүү гарын авлагыг худалдахыг хориглоно.